



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**АЛБАН ТАТВАР СУУТГАН ТӨЛӨГЧ НАРТ ОЛГОЖ
БАЙГАА НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН
БУЦААЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА**

Улаанбаатар хот
2018 он





Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын газрын
захирал бөгөөд тэргүүлэх аудитор
М.Давааням

Аудитын менежер:
З.Ариунзаяа

Ахлах аудитор:
Б.Долгорсүрэн

Аудитор
Б.Хаш-Эрдэнэ
М.Гүнжмаа
Б.Лхагвацэрэн
Н.Эрдэнэбаяр

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар 262451,
дугаарын утас, 323266 дугаарын
факсаар харилцана уу.

Уг тайланг УАГ-ын Веб сайтаас
үзнэ үү.
www.audit.mn

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-3,
Улаанбаатар-15160
Монгол Улс
www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгт, дүрслэлийн товъёог.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл.....	4
Ерөнхий мэдээлэл.....	6
Бүлэг 1. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, түүний үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.....	7
Хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй, цөөн хэдхэн компаниудад НӨАТ-ын буцаалтыг тогтмол, их хэмжээгээр олгосон нь татварын тэгш, шударга байх зарчмыг алдагдуулж байна.....	7
НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хугацааг шалгалтын хамрах хугацаа, АТСТ-ийн үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан үндэслэлтэй тогтоох шаардлагатай байна....	8
Том татвар төлөгчийн НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг дахин хянаж, баталгаажуулахгүй байна.....	9
Татварын тайлангийн систем албан татвар суутган төлөгчид НӨАТ ногдох орлогоос хасагдах зардлыг нэмэгдүүлэх боломжийг олгож байна	9
НӨАТ ногдох орлогоос төлбөр хийгдээгүй НӨАТ-тай худалдан авалтыг хасч, НӨАТ-ын буцаалтыг хууль зөрчин олгосон байна .	9
Хамаарал бүхий этгээдүүд татвараас зайлсхийх зорилгоор үндэслэлгүйгээр худалдан авалтаа нэмэгдүүлсэн байж болзошгүй байна.....	10
НӨАТ-ын илүү төлөлтийг албан татвараас өөр өр төлбөрт шилжүүлэх, АТСТ-ийн харилцагчдын албан татварын өрийг суутган тооцох зэргээр хууль зөрчсөн байна.....	10
Ил тодын тайлан гаргасан АТСТ нарт хууль зөрчин НӨАТ-ын буцаалтыг олгосон байж болзошгүй байна.....	11
Худалдан борлуулах зорилгогүй үндсэн хөрөнгөд төлсөн НӨАТ- ыг НӨАТ ногдох орлогоос хасч, их хэмжээний буцаалтыг олгосон байна.....	11
“НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах акт”-ын загварыг өөрчлөх шаардлагатай байна.....	12
Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын зорилго бүрэн биелээгүй ч Монгол Улсын нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлээгүй, НӨАТ-ын орлого дунджаар нийт татварын орлогын 45.9 хувийг бүрдүүлж байна.	13
НӨАТУС-ийн зорилгыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна	15
НӨАТУС-ээс хэвлэгдсэн нийт баримтын 50.2 хувь баталгаажуагүй байгаа нь иргэдэд хүргэх сургалт сурталчилгааны үр дүн хангалтгүй байгааг харуулж байна	15
Албан татвар төлөгчийн худалдан авалтын төлбөрийн баримтыг НӨАТУС-д автоматаар бүртгэх техник технологийн хөгжүүлэлт хийх шаардлагатай байна	16



НӨАТ-ын урамшуулал олголтын эрсдэлийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож, хянах аргачлалыг сайжруулах шаардлагатай байна.17

Гааль, татвар, санхүүгийн мэдээлэл технологийн төвийн ажилтан НӨАТ-ын урамшууллын сугалаагаар 20.0 сая төгрөг хожсон гэдэг нь үндэслэлгүй байна.....17

Бүлэг 2. Сангийн яам, Татварын ерөнхий газраас тавих дотоод хяналт хангалтгүй, татварын Маргаан таслах зөвлөл бие даасан, хараат бусаар ажиллах эрх зүйн орчин бүрдээгүй байна.....18

Дотоод хяналтыг холбогдох журам, зохицуулалтад нийцүүлэн хэрэгжүүлээгүй байна.....18

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтод Сангийн яамнаас тавих хяналт хангалтгүй байна.....18

ПОС машин нийлүүлэгч компаниудын нэгдсэн бүртгэлгүй, тэдгээрт тавих хяналтгүй байна.....19

Маргаан таслах зөвлөл гомдлыг шийдвэрлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримтлахгүй байна.....19

Үндэслэлгүй акт тогтоосон татварын улсын байцаагчдад Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй уялдуулан хариуцлага тооцох ажил огт хийгдээгүй байна21

Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаа бие даасан, хараат бус, бусдын нөлөөнд үл автах зарчим алдагдах эрсдэлтэй байна21

Дүгнэлт23

Зөвлөмж.....25

Тайлангийн төсөлд Сангийн яамнаас ирүүлсэн санал27

Сангийн яамнаас ирүүлсэн саналд өгөх Үндэсний аудитын газрын тайлбар30

Татварын ерөнхий газраас ирүүлсэн санал31

ТЕГ-ын ирүүлсэн саналд өгөх Үндэсний аудитын газрын тайлбар.34

Хавсралтууд35

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт36

Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал39

Тэмдэглэл40



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
АТСТ	Албан татвар суутган төлөгч
ГТСМТТ	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
МТЗ	Маргаан таслах зөвлөл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НӨАТУС	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОУБ	Олон улсын байгууллага
СЯ	Сангийн яам
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТУБ	Татварын улсын байцаагч
УИХ	Улсын их хурал
УТОХГ	Улсын төсвийн орлого хяналтын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгт, дүрслэлийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	НӨАТ-ын орлого, буцаан олголтын судалгаа	6
Хүснэгт 2	НӨАТ-ын илүү төлөлттэй болон илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргасан АТСТ-ийн судалгаа	7
Хүснэгт 3	НӨАТ-ын илүү төлөлтийг хянаж, баталгаажуулсан хугацааны судалгаа	8
Хүснэгт 4	Хамаарал бүхий этгээдүүдийн хоорондын гүйлгээний судалгаа	10
Хүснэгт 5	2015-2016 онд НӨАТ-ын буцаан олголт авсан барилгын компаниудын судалгаа	13
Хүснэгт 6	НӨАТ-ын баталгаажуулалтын акт, 4 дүгээр хэсэг	13
Хүснэгт 7	Аудитаас санал болгож байгаа НӨАТ-ын баталгаажуулалтын акт, 4 дүгээр хэсэг	
Хүснэгт 8	Дотоодын нийт бүтээгдэхүүн, төсвийн орлого, татварын орлого, НӨАТ-ын орлого, буцаан олголтын судалгаа	14
Хүснэгт 9	ААН илгээгээгүй болон үнийн дүн зөрүүтэй баримтын судалгаа	16
Хүснэгт 10	Хэвлэгдсэн болон баталгаажсан баримтын судалгаа	17
Хүснэгт 11	Татварын албаны дэргэдэх МТЗ-ийн гомдол шийдвэрлэлтийн судалгаа	20
Хүснэгт 12	ТЕГ-ын дэргэдэх МТЗ-ийн гомдол шийдвэрлэлтийн судалгаа	20
Хүснэгт 13	Татварын албаны дэргэдэх МТЗ-ийн шийдвэрлэсэн гомдлын судалгаа	21
Хүснэгт 14	ТЕГ-ын дэргэдэх МТЗ-ийн 2015-2016 онд НӨАТ-ын баталгаажуулалттай холбоотой шийдвэрлэсэн гомдлын талаарх мэдээлэл	21
Дүрслэл 1	АТСТ-ийн илүү төлсөн НӨАТ-ын буцаан олголтыг өөрчлөх санал	8
Дүрслэл 2	Хэвлэгдсэн болон баталгаажсан баримтын судалгаа	17



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах зорилтыг дэвшүүлж, дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтод тавигдах хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад Сангийн яам, Татварын ерөнхий газар, түүний харьяа аймаг, нийслэл дэх Татварын газар, хэлтсээс 2015, 2016 онд байгууллага, иргэдэд хянаж баталгаажуулан олгосон нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын тайлан, статистик мэдээ, маргаан таслах зөвлөлийн болон хяналт шалгалтын тайлан, актууд, байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтүүд, судалгаа, бусад баримт бичгүүдийг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу Сангийн яам, Татварын ерөнхий газар, түүний харьяа аймаг, нийслэл дэх Татварын газар, хэлтсүүдийн удирдлага, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, дотоод хяналт, маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, статистик мэдээ, судалгаа авч, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, түүвэрчлэн шалгах зэрэг арга зүйг ашиглан аудитын арга зүй, хөтөлбөрийн дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Үүнд:

- Татварын Ерөнхий хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2009 оны 22 тогтоолоор батлагдсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”;
- Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журам”, “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох журам”, “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам”;
- Сангийн сайдын 2017 оны 37 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан



Хүндрэл бэрхшээл

олгох журам”, “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам”;

- Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах журам”;
- Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн албан татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж баталгаажуулах, гааль, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хөтлөх журам”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, түүний хавсралт”;
- Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан “Татвар төлөгчийн илүү төлсөн татварыг суутган тооцсон болон буцаан олгосон бүртгэлийг хөтлөх, хянах журам”;
- Татварын ерөнхий газрын даргын 2014 оны 101 дүгээр тушаалаар баталсан "Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам"
- Бусад холбогдох хууль, эрхийн актуудыг шалгуур болгон ашиглав.

Аудитыг гүйцэтгэхэд тулгарсан хүндрэл бэрхшээл

- ТЕГ, СЯ-наас ирүүлсэн тоон мэдээлэл нь вэб сайт болон татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллээс зөрүүтэй байснаас тулган шалгах, тайлбар гаргуулах, асууж тодруулахад хугацаа шаардсан;
- Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Сангийн яамнаас харилцан хамааралтай этгээдүүдийн болон дампуурч татан буугдсан этгээдүүдийн талаарх мэдээлэл, НӨАТ-ыг буцаан авах хүсэлт гаргасан АТСТ нарт иж бүрэн хяналт шалгалт хийж, илүү төлөлтийг баталгаажуулсан тайлан, мэдээ зэргийг гаргуулахад хугацаа шаардагдсан;
- Асуудлын шинжилгээний НӨАТ-ын буцаан олголтын хэрэгжилтээс Монгол Улсын нийгэм, эдийн засагт эерэг, сөрөг нөлөө үзүүлсэн үү? гэсэн асуултад хариулахын тулд татварын асуудлаар мэргэшсэн судлаач, багш нар болон МҮЕА-ын зөвлөх А.Энхбаттай уулзаж, ярилцлага хийж, зөвлөгөө авч хүчин зүйлсийн шинжилгээ хийхийг зорьсон боловч ТЕГ-ын мэдээллийн баазад хангалттай хэмжээний мэдээлэл байгаагүй. /2010 оноос хойшхи мэдээлэл гарах боломжтой/. Онолын хувьд хүчин зүйлсийн нөлөөллийг тооцоход түүврийн хэмжээ доод тал нь 30-40 байх шаардлагатай байдаг. Тиймээс бид аудитын явцад цуглуулсан мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийж хариултыг бэлтгэсэн.
- Аудитын хамрах хүрээ болох 2015,2016 онд ажиллаж байсан татварын улсын байцаагч, удирдлагууд солигдсон тул тодруулга авахад хүндрэлтэй байсан.



Ерөнхий мэдээлэл

Монгол Улсад 1998 онд “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хууль батлагдан мөрдөгдөж эхэлснээс хойш татвар төлөгчдийн бүртгэл, тайлагнал, хяналтыг сайжруулах замаар татварын мэдээллийн баазыг бэхжүүлж, үүний үндсэн дээр зах зээл дэх далд эдийн засгийг бууруулах, улмаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөгжлийн бодлогын зорилтуудад нийцүүлэн тус хуульд нийтдээ 31 удаа нэмэлт өөрчлөлт оруулан 2006 болон 2015 онд шинэчлэн найруулга хийжээ.

НӨАТ-ын буцаан олголт жил тутам нэмэгдэж ирсэн бөгөөд, тэдгээр нь 2012-2016 онд улсын төсөвт төвлөрүүлсэн НӨАТ-ын орлогын 4.6-9.3 хувийг эзэлж байна.

НӨАТ-ын орлогод буцаан олголтын эзлэх хувийн жин 2015 онд 9.3 хувьд хүрч өмнөх оноос 2.8 пунктээр өсч, 2016 онд 8.2 хувьд хүрч өмнөх оноос 1.1 пунктээр буурсан байна.

Татварын албанаас хянаж, баталгаажуулж олгосон НӨАТ-ын буцаан олголт гүйцэтгэлээр 2015 онд 107.5 тэрбум төгрөг, 2016 онд 101.9 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт 1. НӨАТ-ын орлого, буцаан олголтын судалгаа

(тэрбум төгрөг)

Он	НӨАТ-ын орлого	НӨАТ-ын буцаан олголт	НӨАТ-ын орлогод буцаан олголтын эзлэх хувь (3/2)
1	2	3	4
2012	1,359.0	62.5	4.6
2013	1,511.6	76.5	5.1
2014	1,467.2	95.5	6.5
2015	1,157.1	107.5	9.3
2016	1,242.6	101.9	8.2

Эх сурвалж: СЯ-наас ирүүлсэн ирүүлсэн судалгаа

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.13-т “Буцааж олгох албан татвар болон урамшуулал нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн сар, улирал, жилд улсын төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 30 хувиас хэтрэхгүй байна.” гэж заасан байна.

НӨАТ-ын буцаалт болон урамшуулал олгох харилцааг тус хуулийн 15 дугаар зүйлийн дараах заалтаар зохицуулахаар тусгасан байна. Үүнд:

- 15.1-д АТСТ-ийн илүү төлсөн НӨАТ-ыг буцаан олгох,
- 15.2-т албан татвар төлөгчид НӨАТ-ын урамшуулал олгох.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20-д “Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсний төлбөрийн баримтын мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлагнах үйлдэлтэй системийг нэгдсэн систем” гэж тодорхойлсны дагуу НӨАТУС-ийг 2016 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс нэвтрүүлсэн.

АТСТ-ийн илүү төлсөн НӨАТ-ыг буцаан олгох харилцааг Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулах журам”-аар, албан татвар төлөгчид НӨАТ-ын урамшуулал олгох харилцааг Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг буцаан олгох журам”, “Сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам”-аар тус тус зохицуулж байна.

Албан татвар төлөгчид НӨАТ-ын урамшуулал олгох журмын дагуу 2016 оны урамшуулалд зориулж, 18 удаагийн сугалааны тохирлоор 86.1 мянган азтанд 3.6 тэрбум төгрөгийн хонжворыг, АТСТ-өөс худалдан авалт хийсэн 497.5 мянган иргэнд 35.1 тэрбум төгрөгийн НӨАТ-ын буцаан олголтыг тус тус олгожээ.



Бүлэг 1. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, түүний үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна

Хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй, цөөн хэдхэн компаниудад НӨАТ-ын буцаалтыг тогтмол, их хэмжээгээр олгосон нь татварын тэгш, шударга байх зарчмыг алдагдуулж байна

1.1. 2015-2016 онд нийт илүү төлөлттэй АТСТ-ийн 0.9 хувь буюу 147 нь НӨАТ-ын илүү төлөлтөө баталгаажуулж, буцаан авах хүсэлт гаргасан бөгөөд үүний дотор 1 тэрбум төгрөгөөс дээш илүү төлөлттэй АТСТ нарын буцаан авах хүсэлт 2015 онд 40.6 хувь, 2016 онд 73.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2. НӨАТ-ын илүү төлөлттэй болон илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргасан АТСТ-ийн судалгаа

(сая төгрөгөөр)

Илүү төлсөн НӨАТ-ын мөнгөн дүнгийн шатлал	2015 он					
	НӨАТ-ын илүү төлөлттэй		Илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргасан		Илүү төлөлттэй АТСТ-д эзлэх хувь (4/2)	Илүү төлөлтийн дүнд эзлэх хувь (5/3)
	АТСТ-ийн тоо	мөнгөн дүн	АТСТ-ийн тоо	мөнгөн дүн		
1	2	3	4	5	6	7
0-10.0	5,475	9,644.0	8	17.5	0.1%	0.2%
10.0-100.0	1,190	36,599.0	17	857.1	1.4%	2.3%
100.0-1000.0	235	59,223.1	25	9,356.2	10.6%	15.8%
1000.0-10000.0	32	71,534.1	13	30,075.4	40.6%	42.0%
10000.0-50000.0	5	116,515.4	5	119,301.7	100.0%	102.4%
2015 оны нийт дүн	6,937	293,515.6	68	159,607.9	1.0%	54.4%
2016 он						
0-10.0	8,008	11,721.6	9	32.5	0.1%	0.3%
10.0-100.0	1,093	30,330.0	22	979.1	2.0%	3.2%
100.0-1000.0	186	46,692.8	34	12,366.0	18.3%	26.5%
1000.0-10000.0	15	29,561.4	11	39,680.2	73.3%	134.2%
10000.0-50000.0	1	30,065.5	3	93,065.7	300.0%	309.5%
2016 оны нийт дүн	9,303	148,371.2	79	146,123.6	0.8%	98.5%

Эх сурвалж: ТЕГ-ын Татварын хяналт, шалгалтын хэлтсээс ирүүлсэн судалгаа

1.2. Энэ нь албан татвар суутган төлөгч НӨАТ-ын буцаалт авахад хугацаа их зарцуулдаг, шат дамжлага олон, зардал их гардаг болон тэдний татварын боловсрол бага, буцаалт авах эрхтэйгээ мэддэггүй зэргээс шалтгаалжээ.

1.3. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т заасан¹ бараанд “0” /тэг/ хувиар албан татвар ногдуулахаар заасныг үндэслэн 2015-2016 онд экспортын үйл ажиллагаа эрхэлдэг “Энержи ресурс” ХХК, “Шим технолоджи” ХХК, “Ачит ихт” ХХК, “Хангад эксплорэйшн” ХХК-иуд уул, уурхайн эцсийн бүтээгдэхүүн борлуулсны орлогод, “МИАТ” ХК агаарын тээврийн үйл ажиллагааны борлуулалтын орлогод НӨАТ-ын “0” /тэг/ хувь ногдуулж, илүү төлсөн НӨАТ-ын буцаалтыг олон удаагийн давтамжтай, их хэмжээгээр авчээ. **(Хавсралт № 1)**

1.4. Зөвхөн дээр дурдсан АТСТ-ийн 2015-2016 онд НӨАТ-ын буцаан олголтоор авсан 78.5 тэрбум төгрөг нь нийт буцаалтын 42.1 хувийг эзэлж байна.

1.5. Нийт НӨАТ-ын илүү төлөлттэй АТСТ-ийн 0.9 хувь нь НӨАТ-ын буцаалт авах хүсэлт гаргасан, борлуулалтын орлогод нь “0” /тэг/ хувийн татвар ногдуулдаг цөөхөн АТСТ тогтмол, их хэмжээгээр НӨАТ-ын буцаалтыг авч байгаа зэргээс харахад АТСТ нарт олгож байгаа НӨАТ-ын буцаалт үр нөлөөгүй байгааг илтгэж байна.

1.6. Цаашид АТСТ-ийн илүү төлсөн НӨАТ-ын буцаалтыг дараах байдлаар олгох боломжийг судлан төсвийн хөрөнгийг арвич хямгач зарцуулах нь зүйтэй байна.

¹ 12.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрээс экспортод гаргасан, гаалийн байгууллагад мэдүүлсэн бараа



Дүрслэл 1. АТСТ-ийн илүү төлсөн НӨАТ-ын буцаан олголтыг өөрчлөх санал



НӨАТ-ын илүү төлөлтийг салбараар нь ангилж олгох

Борлуулалтад тэг хувь ногдуулж байгаа албан татвар суутган төлөгчийн НӨАТ-ын буцаан олголтыг иргэдийн буцаалттай адил хувь хэмжээтэйгээр (2 хувь) олгох

Албан татвар суутган төлөгчийн улсын төсөвт төлсөн татварын 30 хувиас хэтрүүлэхгүйгээр НӨАТ-ын буцаан олголтыг хийх.

Эх сурвалж: Аудитын багийн санал

НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хугацааг шалгалтын хамрах хугацаа, АТСТ-ийн үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан үндэслэлтэй тогтоох шаардлагатай байна

1.7. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2², 15.7³, Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам”-ын 4 дүгээр зүйлд Татварын албаны НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хугацааг заасан байна.

1.8. Гэвч УТОХГ-ын Татварын хяналт, шалгалтын хэлтсээс 2015 онд хийсэн 16 шалгалтыг 5-65 хоног, 2016 онд 32 хийсэн шалгалтыг 5-123 хоногоор хуульд заасан хугацаанаас хэтрүүлсэн байна.

Хүснэгт 3. НӨАТ-ын илүү төлөлтийг хянаж, баталгаажуулсан хугацааны судалгаа

Он	Ирүүлсэн хүсэлтийн тоо	Хяналт хийхээр баталсан удирдамжийн тоо	Хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн шалгасан удирдамжийн тоо	нийт баталсан удирдамжид хугацаа хэтэрсэн удирдамжийн эзлэх хувь 3/2	Хугацаа хэтэрсэн шалтгаан (тоогоор)					
					АТСТ нотлох баримт ирүүлээгүй	хяналт шалгалтын хамрах хүрээ их	АТСТ-ийн удирдлага, нягтлан бодогч нарт хүндэтгэн үзэх шалтгаан гарсан	Бусад байгууллагаас мэдээлэл, лавлагаа хүлээж байгаа	Татварын улсын байцаагч сэлгэн ажилласан	Төрийн болон хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр байцаагч өөр ажилд түр томилогдсон
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
2015	68	68	16	24%		15			1	
2016	79	79	32	41%	11	16	2	1	1	1

Эх сурвалж: ТЕГ-ын Татварын хяналт, шалгалтын хэлтсээс ирүүлсэн судалгаа

1.9. Хугацаа хэтрэлтийн 50.0-93.8 хувь шалгалтын хамрах хугацаа нэгээс дээш жил байдаг, үйл ажиллагааны чиглэл 34.4 хувь нь АТСТ нотлох баримтыг шаардсан хугацаанд ирүүлээгүй, мөн НӨАТ-ын илүү төлөлтийг баталгаажуулах татварын улсын байцаагчийн тоо цөөнөөс шалтгаалсан байна.

1.10. Ийнхүү НӨАТ-ын ногдуулалт, төлөлтөд баталгаажуулалт хийх хуулийн хугацаа богино байгаа нь татварын улсын байцаагч иж бүрэн шалгалт хийж чадахгүй байх, Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам”-д заасны дагуу 1 АТСТ-ийн НӨАТ-ын илүү

² Харьяалах татварын алба энэ хуулийн 15.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан хянаж баталгаажуулан, албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

³ Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.1.2, 15.4, 15.6-д зааснаар ирүүлсэн хүсэлт, саналыг хүлээн авснаас хойш ажлын долоон өдөрт багтаан хянаж буцаан олгох татварын хэмжээг тодорхойлж, энэ тухай албан татвар төлөгчид бичгээр буюу цахим хэлбэрээр мэдэгдэж, буцааж олгох албан татварын хэмжээ, өрийн дүн зэргийг хянан баталгаажуулж, албан татвар буцаан олгох саналыг ажлын хоёр өдөрт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



төлөлтийн баталгаажуулалтад 2-оос дээш татварын улсын байцаагч оролцох боломжгүй болох эрсдэлийг үүсгэж байна.

1.11. Цаашид Татварын алба НӨАТ-ын илүү төлөлттэй АТСТ бүр илүү төлсөн НӨАТ-ыг буцаан авах хүсэлт гаргах боломжийг бүрдүүлэн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, НӨАТУС-тэй уялдуулах замаар НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулалтыг албан татвар суутган төлөгчийн үйл ажиллагааны чиглэл, шалгалтын хамрах хугацаанаас хамааруулан өөрчлөх нь зүйтэй.

Том татвар төлөгчийн НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг дахин хянаж, баталгаажуулахгүй байна

1.12. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2⁴-т заасныг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Татварын албадын хийсэн НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хяналт, шалгалтыг ТЕГ давхар хянаж, баталгаажуулж байхад УТОХГ-тай харьцдаг АТСТ нар буюу “том” татвар төлөгчдийн НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг дахин хянаж, баталгаажуулдаггүйгээс ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл бий болж байна.

1.13. Цаашид УТОХГ-тай харьцдаг АТСТ-ийн НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хяналтыг сайжруулах, хяналт тавих эрх зүйн тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Татварын тайлангийн систем албан татвар суутган төлөгчид НӨАТ ногдох орлогоос хасагдах зардлыг нэмэгдүүлэх боломжийг олгож байна

1.14. Татварын тайлангийн системд АТСТ бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг бэлтгэн нийлүүлэгчид төлөөгүй байхад падаан бичигдэн борлуулалтын орлого болон худалдан авалт үүсч байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заалттай зөрчилдөж байна.

1.15. Энэ нь АТСТ-чид НӨАТ-тай худалдан авалтаа нэмэгдүүлэх боломжийг олгож, улмаар НӨАТ-ын тайлан бодит бус гарах эрсдэлийг бий болгож байна.

1.16. Цаашид одоогийн ашиглаж байгаа системд бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг төлсөн нөхцөлд худалдан авалтын хасалт хийгддэг байхаар өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

НӨАТ ногдох орлогоос төлбөр хийгдээгүй НӨАТ-тай худалдан авалтыг хасч, НӨАТ-ын буцаалтыг хууль зөрчин олгосон байна

1.17. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1⁵-д албан татвар төлөгчийн төлсөн НӨАТ-ыг түүний төсөвт төлөх НӨАТ-аас хасч тооцохоор заасан боловч татварын улсын байцаагч нар НӨАТ төлөгдөөгүй байхад хасалт хийн илүү төлөлтийг хууль зөрчиж буцаан олгосон байна. Тухайлбал:

-  Татварын улсын байцаагч Б.Халиунаа, Ц.Бундхорол нар “Ачит-Ихт” ХХК-ийн НӨАТ-ын 2015 оны ногдуулалт, төлөлтийг баталгаажуулахдаа “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д 654.3 сая төгрөг төлснөөр баталгаажуулсныг аудитын явцад “Эрдэнэт үйлдвэр” ХХК-тай тус дүнг тулгаж үзэхэд “Ачит-Ихт” ХХК 320.4 сая төгрөгийг төлсөн байна.
-  Татварын улсын байцаагч Р.Долгорсүрэн, П.Отгонсүрэн нар “Шим технологжи” ХХК-ийн 2015.10.01-2015.12.31 хүртэлх НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулахдаа “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д 5,584.8 сая төгрөгийг төлснөөр баталгаажуулсныг аудитын явцад тулгалт хийж үзэхэд 1,061.6 сая төгрөгийг төлсөн байна.
-  Татварын улсын байцаагч Б.Халиунаа, П.Отгонсүрэн нар “Шим технологжи” ХХК-ийн 2016.04.01-2016.06.30 хүртэлх НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулахдаа “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д 1,880.3 сая төгрөгийг төлснөөр баталгаажуулсныг тулгалт хийж үзэхэд 1,790.8 сая төгрөгийг төлсөн байна.

⁴ 15.1.2.харьяалах татварын алба энэ хуулийн 15.1.1-д заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан хянаж баталгаажуулан, албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

⁵ Иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлснээсээ хойшхи хугацаанд энэ хуулийн 7,8,11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн дор дурдсан нэмэгдсэн өртгийн албан татварыг түүний төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцно.



Хамаарал бүхий этгээдүүд татвараас зайлсхийх зорилгоор үндэслэлгүйгээр худалдан авалтаа нэмэгдүүлсэн байж болзошгүй байна

1.18. Улсын төсвөөс 2015-2016 онд хамгийн олон удаагийн давтамжтай, их хэмжээний НӨАТ-ын буцаалт авсан компаниудыг түүвэрлэн худалдан авалтын зардалд дүн, шинжилгээ хийж үзэхэд хамааралтай этгээдүүдийн хооронд хийсэн гүйлгээ 12.7-98.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Хамаарал бүхий этгээдүүдийн хоорондын гүйлгээний судалгаа

(сая төгрөгөөр)

Татвар төлөгчийн нэр	Хамарсан хугацаа	Нийт НӨАТ ногдох зардал	Хамааралтай этгээдүүдийн хооронд хийсэн гүйлгээ	
			Дүн	Хувиар
1	2	3	4	5=4/3*100
Энержи ресурс ХХК	2014.06.01-2015.01.31	470,386.3	113,990.7	41.2
Энержи ресурс ХХК	2015.02.01-2015.06.30	102,088.1	34,922.2	34.2
Энержи ресурс ХХК	2015.07.01-2015.09.30	45,903.9	5,584.8	12.7
Энержи ресурс ХХК	2015.10.01-2015.12.31	284,600.4	68,934.8	24.2
Энержи ресурс ХХК	2016.01.01-2016.08.31	57,617.2	10,926.1	21.4
Витафит инвест ХХК	2013.01.01-2013.12.31	47,093.6	40,570.4	86.1
Шим технологжи ХХК	2015.04.01-2015.09.30	18,609.4	17,306.1	92.9
Шим технологжи ХХК	2015.10.01-2015.12.31	5,630.3	5,584.7	99.2
Шим технологжи ХХК	2016.01.01-2016.03.31	1,520.1	1,423.9	93.7
Шим технологжи ХХК	2016.04.01-2016.06.30	2,359.1	1,880.3	79.7
Ар ди си си ХХК	2014.04.01-2015.03.31	24,131.5	23,865.9	98.9
Таван толгой транс ХХК	2011.01.01-2016.08.31	342,898,426.1	160,415,231.1	46.8

Эх сурвалж: НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийн баталгаажуулалтын акт, аудитын багийн тооцоолол

1.19. ТЕГ-ын УТОХГ нь НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулахдаа хамаарал бүхий этгээдийн хооронд хийгдсэн гүйлгээг иж бүрэн шалгадаггүйгээс тэдгээр нь татвараас зайлсхийх зорилгоор зах зээлийн үнээс доогуур эсвэл өндөр үнээр хоорондоо гэрээ байгуулан НӨАТ-тай худалдан авалтыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн байж болзошгүй байна.

1.20. Цаашид хамаарал бүхий АТСТ нар буюу групп компаниудын НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг бусад албан татварын бүх төрөлтэй уялдуулан шалгах, хийгдсэн гүйлгээнд үнэ шилжилт байгаа эсэхийг тодорхойлох, иж бүрнээр хяналт, шалгалт хийж шаардлагатай байна.

НӨАТ-ын илүү төлөлтийг албан татвараас өөр өр төлбөрт шилжүүлэх, АТСТ-ийн харилцагчдын албан татварын өрийг суутган тооцох зэргээр хууль зөрчсөн байна

1.21. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8⁶-д илүү төлсөн татварыг АТСТ-ийн дараагийн сар, улирал, жилд төлөх албан татварт шилжүүлэн тооцох, төсөвт төлөх бусад төрлийн татварын төлбөрт шилжүүлэн тооцох, татвар төлөгчид буцаан олгохоор заасныг үндэслэн 2015-2016 онд нийт баталгаажуулсан НӨАТ-ын илүү төлөлтийн 18.7 хувь буюу 34.8 тэрбум төгрөгийг буцаан олгож, 81.3 хувь буюу 151.6 тэрбум төгрөгийг суутган тооцуулсан байна.

1.22. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.8.1⁷, 14.8.2⁸ дахь заалтыг зөрчин 2015-2016 онд НӨАТ-ын буцаан олголтыг татвараас өөр төрлийн өр төлбөрт шилжүүлсэн байна. Тухайлбал,

- “Эс Би транс” ХХК-ийн төсвөөс буцаан авах 60.5 сая төгрөгийг тус компанийн Нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд;
- “Шим технологжи” ХХК-ийн төсвөөс буцаан авах 151.9 сая төгрөгийг тус компанийн Нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд;
- “Хаантранс” ХХК-ийн төсвөөс буцаан авах 95.7 сая төгрөгийг тус компанийн Нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд;

⁶ Энэ хуулийн 14.1-д заасны дагуу тухайн сард хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд төлбөл зохих албан татварын дүнгээс их байвал татварын алба дараах байдлаар зохицуулна

⁷ Дараагийн сар, улирал, жилд төлөх албан татварт шилжүүлэн тооцох

⁸ Хууль тогтоомжийн дагуу төсөвт төлөх бусад төрлийн татварын төлбөрт тооцон шилжүүлэх



- “Хаантранс” ХХК-ийн төсвөөс буцаан авах 58.0 сая төгрөгийг тус компанийн хяналт шалгалтын актын төлбөрт;
- “Монгол шевро” ХХК-ийн 5.8 сая төгрөгийг тус компанийн хяналт шалгалтын хүү, торгуульд;
- “Бумбат фрийд лэйн” ХХК-ийн төсвөөс буцаан авах 21.7 сая төгрөгийг тус компанийн хяналт шалгалтын актын төлбөрт;
- “Ар Ди Си Си” ХХК-ийн төсвөөс буцаан авах 148.2 сая төгрөгийг “Моннис интернэшнл” ХХК-ийн хянан шалгалтын актын төлбөрт;
- “Боршоон буянт” ХХК-ийн төсвөөс буцаан авах 102.8 сая төгрөгийг тус компанийн хяналт шалгалтын актын төлбөрт;
- “Тепломакс” ХХК-ийн төсвөөс буцаан авах 1.3 сая төгрөгийг тус компанийн хяналт шалгалтын актын төлбөрт.

1.23. Аудитын явцад илүү төлсөн НӨАТ-ын буцаалтыг өөр татвар төлөгчийн татварын өр төлбөрт шилжүүлсэн дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- “Ар Ди Си Си” ХХК-ийн төсвөөс буцаан авах 148.2 сая төгрөгийг “Моннис интернэшнл” ХХК-ийн хянан шалгалтын актын төлбөрт;
- “Ар Ди Си Си” ХХК-ийн төсвөөс буцаан авах 128.8 сая төгрөгийг “Моннис Пропертиес” ХХК-ийн ААНОАТ-д;
- “Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК-ийн 1,160.0 сая төгрөгийг “Юнивишин” ХХК-ийн НӨАТ-д;
- “Шангри-Ла Улаанбаатар хотел” ХХК-ийн 285.0 сая төгрөгийг “М-Армор” ХХК-ийн НӨАТ-д.

1.24. НӨАТ-ын илүү төлөлтийг АТСТ-ийн тухайн хугацаанд өндөр дүнтэй худалдан авалт хийсэн харилцагч компанийн татварын өр төлбөрт суутган тооцсон байна. Тухайлбал:

- “Энержи ресурс” ХХК-ийн 400.0 сая төгрөгийг “МЕРА” ХХК-ийн НӨАТ-т;
- “Энержи ресурс” ХХК-ийн 2,000.0 сая төгрөгийг “Шунхлай” ХХК-ийн гаалийн албан татварт;
- “Энержи ресурс” ХХК-ийн 2,000.0 сая төгрөгийг “НИК” ХХК-ийн гаалийн албан татварт;
- “Энержи ресурс” ХХК-ийн 3,000.0 сая төгрөгийг “НИК” ХХК-ийн гаалийн албан татварт;
- “Энержи ресурс” ХХК-ийн 5,000.0 сая төгрөгийг “НИК” ХХК-ийн гаалийн албан татварт;
- “Энержи ресурс” ХХК-ийн 4,048.9 сая төгрөгийг “НИК” ХХК-ийн гаалийн албан татварт;
- “Энержи ресурс” ХХК-ийн 1,500.0 сая төгрөгийг “НИК” ХХК-ийн гаалийн албан татварт тус тус суутган тооцуулсан.

Ил тодын тайлан гаргасан АТСТ нарт хууль зөрчин НӨАТ-ын буцаалтыг олгосон байж болзошгүй байна

1.25. Аудитын явцад Татварын алба Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувь хун, хуулийн этгээд хуульд заасан татварын төрлөөр илүү төлөлт тайлагнах, улс, орон нутгийн төсвөөс аливаа авлага үүсгэхийг хориглоно” гэж заасныг зөрчин илүү төлсөн НӨАТ-ын буцаалтыг олгосон эсэхийг тодруулах зорилгоор НӨАТ-ын буцаалт авсан АТСТ нар татварын ямар төрлөөр ил тодын тайлан гаргасан талаарх мэдээллийг авах хүсэлт удаа дараа гаргасан боловч бидэнд ирүүлээгүй болно.

1.26. Татварын алба илүү төлсөн ил тодын тайлан гаргасан эсэхийг хянахгүйгээр АТСТ нарт НӨАТ-ын буцаалтыг олгосон байх эрсдэлтэй байгаа тул хууль хяналтын байгууллагаар шалгуулах шаардлагатай байна.

Худалдан борлуулах зорилгогүй үндсэн хөрөнгөд төлсөн НӨАТ-ыг НӨАТ ногдох орлогоос хасч, их хэмжээний буцаалтыг олгосон байна

1.27. Татварын алба Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн /хуучин/ 14 дүгээр зүйлийн 14.1⁹, 14.1.1¹⁰, 14.1.2¹¹, 14.7¹² дах заалтыг зөрчин худалдан борлуулах зорилгогүй үндсэн хөрөнгөд төлсөн НӨАТ-ыг НӨАТ ногдох борлуулалтаас хассан нь ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй байна. Тухайлбал:

⁹ “Иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан талөгчөөр бүртгүүлснээсээ хойшхи хугацаанд энэ хуулийн 7, 8, 11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн дор дурьдсан нэмэгдсэн өртгийн албан татварыг түүний төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцно.

¹⁰ 14.1.1. үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн.

¹¹ 14.1.2. худалдах, түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар өөрөө шууд импортолсон бараа, ажил, үйлчилгээнд төлсөн.

¹² 14.7. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар импортолсон болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний зарим хэсгийг нь нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох, үлдсэн хэсгийг нь уг татвараас чөлөөлөгдөх үйлдвэрлэл, үйлчилгээнд буюу албан татвар ногдуулахгүй хэрэглээнд ашигласан бол зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигласан хэсгийг нь хасч тооцно.



“Эрдэнэс Монгол” ХХК-ийн НӨАТ ногдох орлогоос “Энержи Ресурс” ХХК-аас худалдан авсан авто зам, боомтын төлбөрийг хасч, 16.0 тэрбум төгрөгийн илүү төлөлтийг буцаан олгосноос 9.4 тэрбум төгрөгийн НӨАТ-ыг 2016 оны 6 дугаар сарын 3-ны өдөр Засгийн газрын өрийн баталгааны шимтгэлд суутган тооцуулсан.

“Ар ди си си” ХХК-ийн НӨАТ ногдох орлогоос авто зам барихтай холбоотой гарсан худалдан авалтыг хасч, 2015 онд 2.4 тэрбум төгрөгийн илүү төлөлтийг буцаан олгожээ.

1.28. НӨАТ ногдох борлуулалтаас үндсэн хөрөнгө худалдан авсан болон үндсэн хөрөнгө бий болгохтой холбоотой худалдан авалтын НӨАТ-ыг хасч, Улсын төсвөөс их хэмжээний буцаалт өгсөн нь НӨАТ-ын хэрэглээний татвар бөгөөд хамгийн эцсийн хэрэглэгч татварыг бүрэн төлдөг зарчмыг алдагдуулсан байна.

1.29. Дээрх нөхцөл байдалд Татварын албаны зарим удирдлагууд хуулийн заалтыг өөр өөрийнхөөрөө шийдвэрлэж, арга зүйгээр хангаж байсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал:

ТЕГ-ын Татварын хяналт шалгалтын удирдлага, арга зүйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэнгийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “... худалдан борлуулах зорилгогүй, өөрийн хэрэгцээнд барьж байгаа үндсэн хөрөнгөд зориулан /өөрийн эцсийн хэрэглэгч/ худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвартай адилтган хасалт хийхгүй” байх талаарх 7/3299 дүгээр албан бичиг;

ТЕГ-ын Дэд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганццэгийн 2014 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн “... өөртөө бий болгосон үндсэн хөрөнгө, хайгуулын ажилд зориулан худалдан авсан бараа ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг хасах талаарх албан бичиг.

ТЕГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Минжирмаагийн 2015 оны 12 дугаар сарын 08-ны УТОХГ-т өгсөн “Бараа материалын ангилалд хамаарагдахгүй, мөн тухайн үед цааш нь борлуулах зорилгогүй эзэмшиж байгаа хөрөнгөд төлсөн НӨАТ-ыг хасч тооцохгүй” байх талаарх 8/3375 дугаар албан бичиг;

1.30. Татварын хуульд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг мөрдлөг болгон ашиглах үүргийг татвар төлөгч нарт хуулиар хүлээлгэсний дагуу НӨАТ-ыг үндсэн хөрөнгийн өртөгт оруулан тооцох нь зүйтэй байна.

1.31. Барилгын салбарын борлуулалт тодорхой хугацааны дараа хүлээн зөвшөөрөгддөг онцлогтой тул барилгын үйл ажиллагаа явуулж байгаа АТСТ нарт илүү төлсөн НӨАТ-ын буцаалтыг олгохгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Хүснэгт 5. 2015-2016 онд НӨАТ-ын буцаан олголт авсан барилгын компаниудын судалгаа

Албан татвар суутган төлөгчийн нэр	Он	/сая төгрөг/ Төрийн сангаас буцаан олголт шилжүүлсэн
Нью Яармаг Хаусинг Прожект ХХК	2016	1090.5
Нью Яармаг Хаусинг Прожект ХХК	2016	1090.5
Тэлмэн констракшн ХХК	2016	250.0
Тэлмэн констракшн ХХК	2016	900.5
Экоскүүл гарден ХХК	2016	239.2
Экоскүүл гарден ХХК	2016	239.2
Эрин Интернэшнл ХХК	2016	596.4
Хан ХХК	2016	4.0
Эс деволупмент ХХК	2016	1041.0
Нийт		5,451.2

Эх сурвалж: Сангийн яам, Татварын ерөнхий газар

1.32. 2015-2016 онд барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг 6 компанид нийт 5,451.2 сая төгрөгийн НӨАТ-ын илүү төлөлтийг буцаан олгож улсын төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

“НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах акт”-ын загварыг өөрчлөх шаардлагатай байна

1.33. Үндэсний татварын ерөнхий газрын /хуучин нэрээр/ даргын 2003 оны 161 дүгээр тушаалаар “Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт төлөлтийг баталгаажуулах акт”-ын загвар анх батлагдаж, Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/150 дугаар тушаалаар шинэчлэгджээ.



1.34. Дээрх журмын 4 дүгээр хэсэгт “Худалдан авалт болон түүнд ногдох НӨАТ”-д зөвхөн худалдан авалт хийсэн компанийн нэр байдгаас тухайн төлбөрийн зориулалтыг харах боломжгүй байна.

Хүснэгт 6. НӨАТ-ын баталгаажуулалтын акт, 4 дүгээр хэсэг

№	Бэлтгэн нийлүүлэгчийн		НӨАТ-ын падааны дугаар	Нийт худалдан авалт			Үүнээс бэлтгэн нийлүүлэгчид төлсөн		Тусгай тэмдэглэгээ
	Нэр	Регистр		Огноо	БАҮ-ний дүн	НӨАТ			

1.35. Энэхүү загвар нь илүү төлсөн НӨАТ-ын баталгаажуулалт хийж байгаа татварын улсын байцаагч болон АТСТ нарын хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэх, улмаар бодит бус акт үйлдэх боломжийг олгох эрсдэлийг бий болгож байна.

1.36. Иймд аудитын багийн зүгээс дараах загварыг санал болгож байна. Үүнд:

Хүснэгт 7. Аудитаас санал болгож байгаа НӨАТ-ын баталгаажуулалтын акт, 4 дүгээр хэсэг

№	Бэлтгэн нийлүүлэгчийн		НӨАТ-ын падааны дугаар	Нийт худалдан авалт			Үүнээс бэлтгэн нийлүүлэгчид төлсөн			
	Нэр	Регистр		Огноо	БАҮ-ний дүн	НӨАТ	Төлбөрийн зориулалт	Төлбөрийн хэлбэр		
								Дансаар	Дансны дугаар	Бэлнээр

Эх сурвалж: Аудитын багийн санал

1.37. Аудитын явцад НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах акттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Гаалиар оруулж ирсэн худалдан авалтыг “Гаалиар” гэж бичсэн, ямар зориулалтаар юу оруулж ирсэн нь тодорхойгүй,
- Худалдан авалтын нийт төлбөрийг хийсэн мэтээр Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн баганад ижил дүнтэйгээр бичсэн.

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын зорилго бүрэн биелээгүй ч Монгол Улсын нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлээгүй, НӨАТ-ын орлого дунджаар нийт татварын орлогын 45.9 хувийг бүрдүүлж байна.

1.38. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд татварын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтуудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн **1. Ажилтай, орлоготой Монгол хүн** хэсэгт “...бизнесийг дэмжсэн татварын хоёр дахь үе шатны шинэчлэлийг хийх”, **3. Эрдэмтэй боловсролтой Монгол хүн хэсэгт** “мэдээллийн тогтолцоог шинэ шатанд гаргаж, улсын нэгдсэн бүртгэлийн цахим мэдээллийг хил, гааль, цагдаа, мэргэжлийн хяналтын дотоод сүлжээтэй холбох”,
- УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 5 дугаар хэсгийн 5.1.2 **“Татварын бодлого” заалтын Стратегийн зорилт 2-т** “...татварын суурийг өргөтгөн татвар хураалтыг сайжруулж, төсвийн орлогыг зохистой нэмэгдүүлнэ”, “...татварын тогтолцоог боловсронгуй болгох”, “татварын илүү төлөлтийг буцаан олгох тогтолцоог нэвтрүүлэх”, “далд эдийн засгийг ил болгох зорилгоор ... зохицуулалтын бусад арга хэрэгслийг оновчтой ашиглах”.

1.39. Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу нэгдсэн ба хэрэглэгчийн системийг нэвтрүүлж, иргэн, ААН-ийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг шууд бүртгэх эрх зүйн болон технологийн шийдлийг бий болгохын зэрэгцээ, худалдан авагчийн оролцоог урамшуулах зорилгоор түүний худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ын 20 хувийг буцаан олгож, хонжворт сугалаанд оролцуулах замаар, татвар төлөгчдийн орлогыг бүртгэлд бүрэн хамруулах үйл ажиллагааг эхлүүлжээ.

1.40. Сангийн яам, ТЕГ-аас НӨАТ-ын буцаан олголтод баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж гаргаагүй, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг урт болон дунд хугацааны стратегийн болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд



нарийвчлан тусгаагүй, тус үйл ажиллагааг зөвхөн хуульд дурдсан бодлого, зорилтын хүрээнд хэрэгжүүлж байна.

1.41. НӨАТ-ын орлого дунджаар нийт татварын орлогын дунджаар 45.9 хувийг, дотоодын нийт бүтээгдэхүүний 6.6 хувийг бүрдүүлж байгаа нь улсын төсөвт эерэг нөлөө үзүүлж байна.

Хүснэгт № 8. Дотоодын нийт бүтээгдэхүүн, төсвийн орлого, татварын орлого, НӨАТ-ын орлого, буцаан олголтын судалгаа

(тэрбум төгрөгөөр)

Он	Дотоодын нийт бүтээгдэхүүн	Төсвийн татварын орлого	НӨАТ-ын орлого (дотоодын+импорт)	НӨАТ-ын буцаан олголт	Хувийн жин			
					Татварын орлого /ДНБ	НӨАТ /ДНБ	НӨАТ / татварын орлого	НӨАТ буцаан олголт /НӨАТ орлого
A	1	2	3	4	5=2/1*100	6=3/1*100	7=3/2*100	8=4/3*100
2012	16,688.4	2,585.6	1,359.0	62.5	15.5	8.1	52.6	4.6
2013	19,174.2	3,196.9	1,511.6	76.5	16.7	7.9	47.3	5.1
2014	22,227.1	3,119.6	1,467.2	95.5	14.0	6.6	47.0	6.5
2015	23,150.4	2,943.4	1,157.1	107.5	12.7	5.0	39.3	9.3
2016	23,886.4	2,854.1	1,242.6	101.9	11.9	5.2	43.5	8.2

Эх сурвалж: СЯ-ны 2017 оны 4-2/3796 дугаар албан бичгээр ирүүлсэн судалгаа

1.42. НӨАТ-ын буцаан олголтын хэмжээг тухайн оны төсвийн бүрэлдэхүүнд оруулан хуульчлан баталдаг тул төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд буцаан олголтоос үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй байна.

1.43. НӨАТУС-ийг нэвтрүүлснээр НӨАТ-ын орлого 2016 онд 1,242.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 7.4 хувиар өссөн байна.

1.44. Дээрх системийн хүрээнд НӨАТ-ын буцаан олголт, сугалааны урамшуулалд зарцуулсан 38.7 тэрбум төгрөгийг 2016 онд өмнөх оноос нэмэгдсэн НӨАТ-ын орлоготой харьцуулбал 2.21 дахин өгөөж бий болгосон буюу 1 төгрөгийн зардал гаргаж, 2 төгрөг 21 мөнгөний ахиу орлогыг олсон байна.

1.45. Татварын албанд бүртгэлтэй 32,845 АТСТ-өөс 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 11.3 хувь буюу 3,711 нь НӨАТУС-ийг ашиглахгүй байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4¹³, Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг буцаан олгох журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1¹⁴ дэх заалтыг тус тус зөрчиж байна.

1.46. Татварын алба татвар төлөгчдийг НӨАТУС-д хамруулах ажлыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс иргэдийг урамшуулах аргаар татварын бааз, суурийг өргөтгөх, татвар төлөгчдийн борлуулалтыг бүртгэлжүүлэх ажил удаашралтай явагдаж байна.

1.47. НӨАТУС-ийг нэвтрүүлээд 2 дахь жилдээ орж байгаа боловч нийслэлийн хэмжээнд нийт 186 зах, худалдааны төв болон түүнээс бусад цэгүүдэд төлбөрийн баримт олгох үүрэг бүхий бизнес, худалдаа, үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгчдийн 34.5 хувь тус системд холбогдсон нь худалдан авагчийг урамшуулах замаар татвар төлөгчдийг бүртгэлд бүрэн хамруулах зорилт дутуу хэрэгжсэнтэй холбоотой байна.

¹³ АТСТ хэрэглэгчийн системтэй байна.

¹⁴ АТСТ хэрэглэгчийн системийг заавал ашиглана.



НӨАТУС-ийн зорилгыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна

1.48. Борлуулалтын орлогын хэмжээ 50.0 сая төгрөгт хүрээгүй буюу АТСТ биш 184,815 иргэн, ААН-ийн 88.0 хувь буюу 162,617 нь НӨАТУС-д бүртгүүлээгүй байгаа нь тэдгээрийг НӨАТУС-д бүртгэх шаардлагыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт байхгүй, иргэн, ААН татвараас зайлсхийх хандлагатай байдгаас шалтгаалж байна.

1.49. АТСТ биш иргэн, ААН-үүдийн дийлэнх нь НӨАТУС-д бүртгүүлээгүй, зарим АТСТ нар НӨАТУС-ийг бүрэн ашиглахгүй байгаагаас албан татвар төлөгч нар НӨАТ-ын урамшуулалд бүрэн хамрагдахгүй, татвар төлөгчдийн борлуулалт бүрэн бүртгэгдэхгүй байх эрсдэл үүсч байна.

1.50. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.3¹⁵, Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг буцаан олгох журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2¹⁶, 5.3¹⁷ дахь заалтыг тус тус зөрчин зарим АТСТ нар борлуулалтын баримтыг иргэдэд олгосон ч борлуулалтын мэдээллийг НӨАТУС-д илгээгээгүй байна.

1.51. Энэ нь борлуулалтын мэдээллийг илгээгээгүй зөрчилд хариуцлага тооцох эрх зүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалж байна.

Хүснэгт 9. ААН илгээгээгүй болон үнийн дүн зөрүүтэй баримтын судалгаа

(мянган ширхэг)

он	Татварын нэгдсэн системд борлуулалтын мэдээллээ журамд заасан хугацаанд илгээгээгүй		Нэгдсэн системд борлуулалтын мэдээллээ огт илгээгээгүй /		Үнийн дүн зөрүүтэй
	ААН-ийн тоо	Баримтын тоо	ААН-ийн тоо	Баримтын тоо	Баримтын тоо
2016.VI	20.1	8,010.5	21.0	356.4	1,259.0
2017.VI	26.0	10,857.2	19.9	313.2	1,517.7

Эх сурвалж: ГТСМТТ-ийн мэдээллийн бааз

НӨАТУС-ээс хэвлэгдсэн нийт баримтын 50.2 хувь баталгаажсаагүй байгаа нь иргэдэд хүргэх сургалт сурталчилгааны үр дүн хангалтгүй байгааг харуулж байна

1.52. НӨАТУС-ээс 2017 оны эхний хагас жилийн байдлаар 361.1 сая баримт хэвлэгдсэнээс 49.8 хувь буюу 179.8 сая баримт нь баталгаажсан байна.

Хүснэгт 10. Хэвлэгдсэн болон баталгаажсан баримтын судалгаа

(сая ширхэг)

Хэвлэгдсэн баримт	Баталгаажсан баримт	Зөрүү	
		Дүнгээр (1-2)	Хувиар (2/1)
1	2	3	4
102.6	50.1	52.5	48.8
219.8	99.4	120.4	45.2
361.1	179.8	181.3	49.8

Эх сурвалж: ГТСМТТ-ийн мэдээллийн бааз

1.53. НӨАТУС-ээс хэвлэгдсэн нийт баримтын 50.2 хувь буюу 181.3 сая баримт баталгаажсаагүй байгаа нь зарим иргэн, ААН борлуулалтын мэдээллийг НӨАТУС-д илгээгээгүй, олгосон баримтыг албан татвар төлөгч бүртгүүлээгүй, мэдээллийг зөрүүтэй бүртгүүлсэнтэй холбоотой бөгөөд үүнээс шалтгаалан иргэд урамшууллын буцаан олголтыг бүрэн авахгүй, сугалаанд хамрагдах боломжгүй болж байна.

¹⁵ Хэрэглэгчийн системд бүртгэсэн төлбөрийн баримтын мэдээллийг гурав хоногийн дотор багтаан борлуулалтын нэгдсэн системд илгээнэ.


¹⁶ АТСТ нь бараа, ажил, үйлчилгээ борлуулсан тухай бүрт албан татвар төлөгчид стандартын шаардлага хангасан НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т заасан төлбөрийн баримтыг заавал өгч мэдээллийг тухай бүр нэгдсэн системд дамжуулна

¹⁷ "АТСТ-ийн техникийн нөхцөлөөс хамаарч энэ журмын 5.2-т заасан мэдээллийг тухай бүр дамжуулах боломжгүй бол 3 хоног тутам дамжуулах үүрэгтэй"



Дүрслэл 2. Хэвлэгдсэн болон баталгаажсан баримтын судалгаа

(сараар)



Эх сурвалж: ГТСМТТ-ийн мэдээллийн бааз

1.54. Судалгаанаас харахад 2016 оны албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ын буцаан олголтыг 2017 оны 2 дугаар сард олгож эхэлснээс хойш иргэдийн баримтаа бүртгүүлэх хандлага эрс өссөн байна.

1.55. Иймд албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг буцаан олгох давтамжийг ойртуулах буюу дор хаяж улирал тутамд олгох замаар иргэдийг идэвхжүүлснээр АТСТ-ийн борлуулалтын орлогыг бүртгэлжүүлэх, тэдний борлуулалтын орлогод тавих хяналтын үр нөлөө дээшлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

1.56. Татвар төлөгчид борлуулалтын мэдээллээ журамд заасан хугацаанд НӨАТУС-д илгээгээгүй, зөрүүтэй илгээсэн тохиолдолд тус мэдээллийг иргэдээс шууд хүлээн авах, шуурхай шийдвэрлэх боломжийг тус системд бүрдүүлээгүй нь Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг буцаан олгох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3-т “... нэгдсэн системээр дамжуулан татварын албанд мэдэгдэнэ” гэж заасныг хэрэгжүүлэх боломжгүй болгож байна.

Албан татвар төлөгчийн худалдан авалтын төлбөрийн баримтыг НӨАТУС-д автоматаар бүртгэх техник технологийн хөгжүүлэлт хийх шаардлагатай байна

1.57. Албан татвар төлөгчийн 2016 оны худалдан авалтад төлсөн НӨАТ-ын буцаан олголтод 620.4 мянган албан татвар төлөгчдөд 35.5 тэрбум төгрөгийг олгохоос 497.5 мянган албан татвар төлөгчид 35.1 тэрбум төгрөгийг олгожээ. Энэ нь албан татвар төлөгчийн 80.2 хувь, буцаан олгох мөнгөн дүнгийн 98.4 хувийг тус тус эзэлж байна.

1.58. 2017 оны эхний хагас жилийн байдлаар НӨАТ-ын буцаан олголтыг авбал зохих нийт татвар төлөгчийн 122.9 мянга буюу 19.8 хувь нь 461.3 сая төгрөгийн буцаан олголтыг аваагүй байна. Энэ нь тэдний хувийн мэдээлэл бүрэн бус, дансны мэдээлэл зөрүүтэй, хамтран эзэмшигчтэй данс бүртгүүлснээс шалтгаалсан байна.

1.59. Монгол банк дахь буцаан олголтын тусгай данс 461.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тус үлдэгдлийг тодорхой давтамжтайгаар улсын төсөвт төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүйтэй холбоотой байна.

1.60. Иймд олон улсад урамшууллын системийг амжилттай хэрэгжүүлсэн сайн туршлагаас харахад НӨАТУС-д худалдан авалтын мэдээлэл автоматаар бүртгэгдэх техник, технологийн хөгжүүлэлт хийж, картын системд шилжүүлснээр албан татвар төлөгчдийн баримт шивэх ажиллагаа хялбар болж, Татварын албаны хянах боломжгүй эрсдэл багасч, татварын бааз, суурь нэмэгдэнэ гэж үзэж байна.



НӨАТ-ын урамшуулал олголтын эрсдэлийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож, хянах аргачлалыг сайжруулах шаардлагатай байна.

1.61. ТЕГ нь НӨАТ-ын урамшууллыг олгох үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналтын арга хэрэгслийг нэвтрүүлж, зөвхөн 1 удаагийн сугалааны тохирлоор 3 буюу түүнээс дээш хонжвор хожсон 256 тохиолдлыг хянаж, 61 албан татвар төлөгчид хамаарах 13.9 сая төгрөгийн хонжворыг олгохоос татгалзаж, 2016 онд 20 сая төгрөгөөс дээш худалдан авалт хийсэн 1253 албан татвар төлөгчийн нийт 2,383.0 сая төгрөгийн буцаан олголтыг хянаж, 74 албан татвар төлөгчид хамаарах 116.1 сая төгрөгийн урамшууллыг буцаан олгоогүй байна.

1.62. Гэвч энэ аргачлалаар хяналт шалгалт явуулахад бөөний үнээр 20.0 сая төгрөгөөс доош үнийн дүнтэй худалдан авалт тогтмол хийдэг жижиглэнгийн худалдаа, дэлгүүр ажиллуулдаг албан татвар төлөгч нар НӨАТ-ын буцаан олголтын хяналт шалгалтад хамрагдахгүй, НӨАТУС-д бүртгэгдсэн дүнгээр буцаан олголт шууд авах нөхцөл бүрдэж байна.

1.63. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹⁸, 15 дугаар зүйлийн 15.3¹⁹, Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар баталсан “Сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1²⁰-д заасан шалгуур бүрэн хангагдаагүй байхад НӨАТ-ын урамшууллыг олгох эрсдэл үүсч байна.

1.64. Тиймээс НӨАТ-ын урамшууллыг олгох үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналтын нарийвчилсан арга хэрэгслийг нэвтрүүлж, хууль, тогтоомжийн шаардлагад нийцсэн байдлаар хяналт хийх шаардлагатай байна.

Гааль, татвар, санхүүгийн мэдээлэл технологийн төвийн ажилтан НӨАТ-ын урамшууллын сугалаагаар 20.0 сая төгрөг хожсон гэдэг нь үндэслэлгүй байна

1.65. Сангийн яамны харьяа Гааль, татвар, санхүүгийн мэдээлэл технологийн төв УҮГ-ын ажлаас чөлөөлөгдсөн болон одоо ажиллаж байгаа болон ажилтнууд 2016-аас 2017 оны 9 дүгээр сар хүртэлх хугацаанд НӨАТ-ын урамшууллын сугалааны тохирлоор азтан болсон эсэхэд тулган баталгаажуулалт хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Дээрх хугацаанд ажлаас чөлөөлөгдсөн 18 ажилтан байгаагаас 5 нь азтан болж 1-ээс 3 удаагийн давтамжтай, 1 удаагийн хонжвороор тус бүр 20.0 мянган төгрөг хожсон байна.
- Одоо ажиллаж байгаа 46 ажилтны 10 нь азтан болж 1-ээс 2 удаагийн давтамжтай 20.0-оос 100.0 мянган төгрөг хожсон байгаагаас үзэхэд тус газрын ажилтан сугалаагаар 20.0 сая төгрөг хожсон гэдэг нь үндэслэлгүй байна.

¹⁸ Бараа, ажил, үйлчилгээг аливаа хэлбэрээр борлуулахгүй, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн өөртөө хэрэглэх зориулалтаар худалдан авч, импортоор оруулсан хувь хүнийг албан татвар төлөгч гэнэ.

¹⁹ Албан татвар төлөгчид буцаан олголтыг дараах нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд олгоно: 15.3.1. албан татвар суутган төлөгчөөс худалдан авсан байх, 15.3.2. худалдан авалт татварын албанд бүртгэгдсэн байх, 15.3.3. албан татвар ногдсон бараа, ажил, үйлчилгээ байх, 15.3.4. бүртгэлийн хэрэгсэл буюу бүртгэлийн машинд бүртгэгдсэн байх.

²⁰ Татварын алба нь албан татвар төлөгчийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний зориулалт нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 15 дугаар зүйлийн 15.3 дэх хэсэгт заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг хянах



Бүлэг 2. Сангийн яам, Татварын ерөнхий газраас тавих дотоод хяналт хангалтгүй, татварын Маргаан таслах зөвлөл бие даасан, хараат бусаар ажиллах эрх зүйн орчин бүрдээгүй байна

Дотоод хяналтыг холбогдох журам, зохицуулалтад нийцүүлэн хэрэгжүүлээгүй байна

2.1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5²¹-д “Сангийн сайд татварын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ.” гэж заасан боловч 2012 оноос хойш СЯ-наас НӨАТ, НӨАТ-ын буцаан олголттой холбоотой хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

2.2. ТЕГ-аас хийх хяналт, шалгалтын үйл ажиллагаа хангалтгүй хийгдэж байгаагаас Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.3, 17.4, Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг буцаан олгох журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.3 дахь заалтууд бүрэн хэрэгжээгүй, Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар батлагдсан “Сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.9²², “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг буцаан олгох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтууд огт хэрэгжээгүй байна.

Төрийн өмчийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, зохиогчийн эрхийг баталгаажуулаагүйгээс өмч, хөрөнгөд эрсдэл гарч болзошгүй байна

2.3. Засгийн Газрын 2014 оны 285 дугаар тогтоолоор НӨАТУС-ийг хөгжүүлэх төслийн нэгжийг байгуулсан боловч түүнийг Засгийн газрын 2016 оны 120 дугаар тогтоолоор татан буулгаж, Гааль, татварын ерөнхий газрын дэргэдэх “Гааль, татварын мэдээллийн технологийн төв” УТҮГ болгон өөрчлөн байгуулсан байна.

2.4. ТЕГ-ын захиалгаар НӨАТУС-ийг хөгжүүлэх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, гүйцэтгүүлсэн боловч тус системийн өртгийг бүрэн тодорхойлоогүй, зохиогчийн эрхийг баталгаажуулаагүйгээс тус хөрөнгийг НББ-д тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4²³ дахь заалтыг зөрчсөн байна. Энэ нь ТЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, түүнд Дотоод аудитын газраас хяналт тавих үүргээ биелүүлээгүйтэй холбоотой байна.

2.5. НӨАТУС-ийг хөгжүүлэхтэй холбоотой ажил гүйцэтгэх гэрээ, тендерийн баримт бичиг, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, төлбөрийн хүсэлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад материалууд ТЕГ болон ГТСМТТ-д бүрэн архивлагдаагүйгээс шалтгаалж, тус системийн өртгийг аудитын явцад нягтлан шалгах боломжгүй байлаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтод Сангийн яамнаас тавих хяналт хангалтгүй байна

2.6. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8²⁴, Сангийн сайдын 333 дугаар тушаалаар баталсан “НӨАТ-ын хасалт хийх, буцаан олгох тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.1²⁵-д Сангийн яам ТЕГ-аас ирүүлсэн НӨАТ-ын буцаан олголтын саналыг ажлын 45 хоногт хянаж, шийдвэрлэнэ гэж заасан байна.

²¹ Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ: 6/Сангийн сайд: татварын бодлого

²² Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улирал бүрийн эцэст тооцоо хийн тусгай данс үлдэгдэлтэй бол санхүүжилт хийсэн данс руу буцаан төвлөрүүлнэ”

²³ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

²⁴ “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага саналыг хүлээн авснаасаа хойш ажлын 45 өдөрт багтаан албан татварыг буцаан олгох шийдвэр гаргана”;

²⁵ “Төсвийн бодлого, төлөвлөлт хариуцсан нэгж нь саналыг хүлээн авснаас хойш ажлын 40 хоногт багтаан саналыг хянаж...”



2.7. Сангийн яамны НӨАТ-ын буцаалтыг хянах хугацаа Татварын албаны хянах хугацаанаас их байхад Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын НӨАТ-ын буцаалт хариуцсан мэргэжилтэн улсын байцаагчийн эрхгүй, НӨАТ-ын буцаалтын актаар баталгаажсан жагсаалт, тооцоог шууд АТСТ-тэй харьцан дахин шалгаж баталгаажуулах боломжийг дээр дурдсан журамд тодорхой тусгаж өгөөгүй байна.

2.8. Иймд Сангийн яамнаас НӨАТ-ын буцаалтад тавих хяналтыг тодорхой заасан эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

ПОС машин нийлүүлэгч компаниудын нэгдсэн бүртгэлгүй, тэдгээрт тавих хяналтгүй байна

2.9. Сангийн яамны харьяа Гааль, татвар санхүүгийн мэдээллийн технологийн төвд бүртгэлтэй ПОС машин нийлүүлэгч компанийн тоо 2017 оны байдлаар 64 байгаа бөгөөд улсын хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг бүртгэх, хэрхэн хянах талаар эрх зүйн зохицуулалтгүй байна.

2.10. Иймд ТЕГ болон Сангийн яам ПОС машин нийлүүлэгч компаниудыг бүртгэлжүүлж, хяналтын тогтолцоо, эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

Маргаан таслах зөвлөл гомдлыг шийдвэрлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримтлахгүй байна

2.11. Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ын хүрээнд Татварын албаны дэргэдэх МТЗ-ийн ажиллах эрх зүйн зохицуулалтыг бий болгожээ.

2.12. Татварын МТЗ нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бие даасан, хараат бус, бусдын нөлөөнд үл автах зарчмыг баримталж, шүүхийн байгууллагын нэгэн адил татвар төлөгч, татварын албаны хооронд үүссэн маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, магадлан шийдвэрлэх чиг үүрэгтэй бөгөөд Сангийн сайдын тушаалаар томилсон 11 гишүүний бүрэлдэхүүнтэй ТЕГ-ын дэргэдэх МТЗ, ТЕГ-ын даргын тушаалаар томилсон 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй аймаг, нийслэлийн Татварын газар, хэлтсийн дэргэдэх МТЗ тус тус ажиллаж байна.

2.13. Татварын албаны дэргэдэх МТЗ татварын улсын байцаагчийн актад холбогдох 2015 онд 2,487.2 тэрбум төгрөгийн зөрчилд тогтоосон 221.7 тэрбум төгрөгийн 275 гомдол, 2016 онд 550.3 тэрбум төгрөгийн зөрчилд тогтоосон 116.5 тэрбум төгрөгийн 82 гомдлыг тус тус хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 11. Татварын албаны дэргэдэх МТЗ-ийн гомдол шийдвэрлэлтийн судалгаа

(тоогоор)

он	Шийдвэрлэх гомдол			Шийдвэрлэсэн гомдол		
	Өмнөх оноос шилжиж ирсэн	Тайлант онд шинээр ирсэн	Нийт дүн (2+3)	Татвар төлөгч гомдлоо буцаасан	Шийдвэрлэсэн	Оны эцэст хяналт хийгдэж байгаа (4-5-6)
1	2	3	4	5	6	7
2015	84	293	377	22	275	80
2016	80	131	211	0	82	129

Эх сурвалж: ТЕГ-ын дэргэдэх Маргаан таслах зөвлөлөөс ирүүлсэн судалгаа

2.14. Татварын албаны дэргэдэх МТЗ шийдвэрлэх гомдлоос 2015 онд 73.0 хувийг бүрэн шийдвэрлэж, 5.8 хувийг татвар төлөгч гомдлоо буцааж, 21.2 хувийг хяналт хийгдэж байгаа, 2016 онд 38.9 хувийг бүрэн шийдвэрлэж, 61.1 хувийг хяналт хийгдэж байна.



Хүснэгт 12. ТЕГ-ын дэргэдэх МТЗ-ийн гомдол шийдвэрлэлтийн судалгаа

Он	Татвар төлөгчөөс ирүүлсэн гомдлын тоо	Гомдол шийдвэрлэсэн хугацаа												Захиргааны хэргийн шүүхэд шилжсэн гомдлын тоо	МТЗ-ийн тогтоолыг ТЕГ- ын даргын тушаалаар баталгаажуулахад зарцуулсан дундаж хоног
		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн гомдлын тоо	Хэтэрсэн хугацаа (сараар)												
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11		
2015	114	52	23	19	7	2	4	3	3		1		61	19	
2016	51	20	12	1	10	2	1	2	1			1	28	18	

Эх сурвалж: ТЕГ-ын дэргэдэх Маргаан таслах зөвлөлөөс ирүүлсэн судалгаа

2.15. ТЕГ-ын дэргэдэх МТЗ-д татвар төлөгчөөс 2015-2016 онд ирүүлсэн нийт гомдлын 54.4-60.8 хувийг нь хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн шийдвэрлэсэн байна.

2.16. Гомдол шийдвэрлэх хугацааг хэтрүүлсэн нь татвар төлөгчийн талаас хугацааг сунгах хүсэлт гаргасан, нотлох баримт ирүүлэхээр заасан хугацаанд гаргаж өгөөгүй, Татварын албаны зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг өөрчлөгдсөн, тодорхой шалтгааны улмаас МТЗ-ийн ирц бүрдээгүй, нэмэлт мэдээлэл авах зорилгоор хууль, хяналтын болон бусад холбогдох байгууллагад хүргүүлсэн лавлагаа, хүсэлтийн хариу ирээгүй зэргээс шалтгаалсан байна.

2.17. Энэ нь “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.1, Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

2.18. Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ын 5.5-д “Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг 7 хоногийн дотор тухайн шатны Татварын албаны даргад хүргүүлнэ. Татварын албаны дарга шийдвэрийг 3 хоногийн дотор тушаалаараа баталгаажуулах” гэж заасан боловч ТЕГ-ын дэргэдэх МТЗ-ийн шийдвэрийг баталгаажуулахад тус газрын дарга дунджаар 2015 онд 19 хоног, 2016 онд 18 хоног зарцуулсан нь татвар төлөгчөөс ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх хугацаа хэтрэхэд нөлөөлсөн байна.

Хүснэгт 13. Татварын албаны дэргэдэх МТЗ-ийн шийдвэрлэсэн гомдлын судалгаа

/сая төгрөгөөр/

он	ТУБ-ийн акт		МТЗ-ийн хурлаар өөрчилсөн буюу хүчингүй болгосон		МТЗ-ийн хурлаар төлүүлэхээр шийдвэрлэсэн	
	Зөрчлийн дүн	Тогтоосон төлбөрийн дүн	Зөрчлийн дүн	Тогтоосон төлбөрийн дүн	Зөрчлийн дүн	Тогтоосон төлбөрийн дүн
1	2	3	4	5	6	7
2015	2,487,156.6	221,723.0	309,447.9	51,945.8	2,177,708.7	169,777.2
2016	550,295.5	116,510.3	16,323.7	2,535.2	533,971.7	113,975.1

Эх сурвалж: ТЕГ-ын дэргэдэх Маргаан таслах зөвлөлөөс ирүүлсэн судалгаа

2.19. ТЕГ-ын дэргэдэх МТЗ 2015-2016 онд НӨАТ-ын баталгаажуулалттай холбоотой татвар төлөгчийн гаргасан 12 гомдлыг хэлэлцэж, татварын улсын байцаагчийн тогтоосон төлбөрийн акт хуулийн үндэслэлтэй болохыг тогтоон татвар төлөгчөөр биелэлтийг хангуулахаар шийдвэрлэсэн байна.



Хүснэгт № 14. ТЕГ-ын дэргэдэх МТЗ-ийн 2015-2016 онд НӨАТ-ын баталгаажуулалттай холбоотой шийдвэрлэсэн гомдлын талаарх мэдээлэл (сая төгрөгөөр)

Он	Зөрчлийн дүн	тоо	Мөнгөн дүн
2015 он	28,815.0	9	2,837.4 сая
2016 он	196,765.6	3	19,673.9

2.20. ТЕГ-ын дэргэдэх МТЗ-ийн 2015-2016 онд хэлэлцэж шийдвэрлэсэн татварын улсын байцаагчийн тогтоосон 12 төлбөрийн актыг татвар төлөгч хүлээн зөвшөөрөхгүй, Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргасан байна.

2.21. Захиргааны хэргийн хяналтын шатны шүүх татварын улсын байцаагчийн тогтоосон 2,471.3 сая төгрөгийн төлбөрийн актыг татвар төлөгчөөр биелэлтийг хангуулах, 1,515.1 сая төгрөгийн төлбөрийн акт хуулийн үндэслэлгүй тул хүчингүй болгох, 18,480.2 сая төгрөгийн төлбөрийн актыг түдгэлзүүлэх шийдвэрийг гаргасан байна.

Үндэслэлгүй акт тогтоосон татварын улсын байцаагчдад Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй уялдуулан хариуцлага тооцох ажил огт хийгдээгүй байна

2.22. МТЗ-ийн тогтоолоор 2015 онд 309,447.9 сая төгрөгийн зөрчилд тогтоосон 51,945.8 сая төгрөгийн ТУБ-ийн акт, 2016 онд 16,323.7 сая төгрөгийн зөрчилд тогтоосон 2,535.2 сая төгрөгийн ТУБ-ийн актыг хууль зүйн үндэслэлгүй болохыг тогтоож, бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгожээ.

2.23. Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.6-д “Татварын улсын байцаагчийн акт, дүгнэлт хууль зүйн үндэслэлгүй нь тогтоогдвол түүнийг бичсэн ТУБ-д Татварын ерөнхий хуулийн 73.2-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг ТЕГ-ын даргад тавих” гэж заасан боловч 2017 оны 9 дүгээр сарын байдлаар хариуцлага тооцох санал огт гаргаагүй байгаа тул зөрчлийг арилгуулж, хариуцлагыг нөхөн тооцох шаардлагатай байна.

2.24. Захиргааны хэргийн шүүх, Татварын албаны дэргэдэх МТЗ-өөс 2015,2016 онд ТУБ-ийн актаар тогтоосон 80.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг татвар төлөгчөөр төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн шүүх болон МТЗ-өөр татварын маргаан хянагдаж, шийдвэрлэгдэх хүртэл хугацаа (дунджаар нэг жил)-нд ТУБ-ийн актаар тогтоосон нөхөн төлбөрийн дүнд алданги, торгууль тооцогдохгүй байгаагаас зарим татвар төлөгч хугацаа хожих зорилгоор гомдол гаргах эрсдэлийг бий болгож байна.

2.25. ТЕГ-ын дэргэдэх МТЗ 2015-2016 онд нийт 165 гомдол шийдвэрлэснээс 54.5 хувь буюу 90 нь Захиргааны хэргийн шүүхэд ТУБ-ын актаар тогтоосон захиргааны шийдвэрт гомдол гаргасан байх бөгөөд тус шүүх нийт 26 гомдолд холбогдох 101,263.0 сая төгрөгийн ТУБ-ийн актыг хүчингүй болгож, татвар төлөгчийн талд шийдвэр гаргасан байна.

Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаа бие даасан, хараат бус, бусдын нөлөөнд үл автах зарчим алдагдах эрсдэлтэй байна

2.26. Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6²⁶, 27.6.8²⁷, 42 дугаар зүйлийн 42.3²⁸, 42.8²⁹, Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ын 3.2³⁰ дахь заалтын дагуу МТЗ-ийн шийдвэрийг ТЕГ-ын дарга хянаж

²⁶ Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

²⁷ татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хянаж баталгаажуулах, эсхүл өөрчлөх, хүчингүй болгох;

²⁸ аймаг, нийслэлийн татварын хэлтэс, газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийг 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Үндэсний татварын ерөнхий газрын дарга тус тус батална.

²⁹ Маргаан таслах зөвлөлийн тогтоолыг тухайн шатны татварын албаны дарга тушаал гарган баталгаажуулах бөгөөд ийнхүү баталгаажуулах үндэслэлгүй гэж үзвэл шалтгааныг тодорхой тусгасан тайлбарын хамт Маргаан таслах зөвлөлд буцаана.

³⁰ Аймгийн татварын хэлтсийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн магадлагчийг тухайн татварын албаны даргын, Татварын ерөнхий газар болон нийслэлийн татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн магадлагчийг Татварын ерөнхий газрын даргын тушаалаар тус тус 3 жилийн хугацаагаар томилно. Магадлагчаар нэг удаа улируулан томилж болно.



баталгаажуулах, өөрчлөх, хүчингүй болгохоор заасан нь тус зөвлөлийн бие даасан, хараат бус, бусдын нөлөөнд үл автах зарчмыг алдагдуулах эрсдэлийг үүсгэж байна.

2.27. ТЕГ болон нийслэлийн Татварын газрын дэргэдэх МТЗ-ийн магадлагчийг ТЕГ-ын дарга, аймгийн Татварын хэлтсийн дэргэдэх МТЗ-ийн магадлагчийг тухайн Татварын хэлтсийн даргын тушаалаар томилдог бөгөөд бүтцийн хувьд тухайн Татварын албаны хуулийн болон захиргааны газар, хэлтэст харьяалагдаж, ажлын байрны тодорхойлолтоор татварын улсын байцаагч, магадлагч нэртэйгээр хуулийн хэлтсийн даргын өгсөн үүрэг, даалгаврыг шууд биелүүлэхээр баталсан нь магадлагчийн хууль дээдлэх, хараат бус, бусдын нөлөөнд үл автах үндсэн зарчмыг алдагдуулж байна.

2.28. Татварын “Маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.1³¹-т Татвар төлөгчийг ТЕГ-ын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй холбоотой гомдлыг шүүхэд гаргах эрхтэй гэж заасан боловч тус журмын 6.3-т тодорхойлсон татварын улсын байцаагчийн эрх, үүрэгт энэ талаар огт тусгаж өгөөгүй байна.

2.29. Иймд Татварын улсын байцаагч нар маргаан таслах зөвлөлийн шийдвэрт гомдолтой байх тохиолдолд шүүхэд хандах эрхийг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

³¹ Татварын акт, дүгнэлт болон Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй танилцаж, үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо энэхүү журмын 1.6-д заасан харьяаллын дагуу гаргах



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын бодлогыг хэрэгжүүлэх зорилго бүрэн биелээгүй байна.
- Хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй, уул, уурхайн бүтээгдэхүүний экспорт, агаарын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг цөөн хэдхэн компаниудад НӨАТ-ын илүү төлөлтийг тогтмол, их хэмжээгээр буцаан олгосон нь татварын тэгш, шударга байх зарчмыг алдагдуулж байна.
- НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хугацааг тухайн шалгалтын хамрах хугацаа, АТСТ-ийн үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан үндэслэлтэй тогтоох шаардлагатай байна.
- Том татвар төлөгчийн НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг дахин хянаж, баталгаажуулахгүй байна.
- Хамаарал бүхий этгээдүүд татвараас зайлсхийх зорилгоор худалдан авалтаа үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн байж болзошгүй байна.
- Татварын алба НӨАТ-ын илүү төлөлтийг албан татвараас өөр төрлийн өр төлбөр болон өөр АТСТ-ийн өр төлбөрт хууль зөрчин шилжүүлсэн байна.
- Барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг АТСТ нарт илүү төлсөн НӨАТ-ын буцаалтыг олгох шаардлагагүй байна.
- НӨАТУС-ийг нэвтрүүлснээр НӨАТ-ын орлого 2016 онд 1,242.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 7.4 хувиар өсч, тус системийн хүрээнд НӨАТ-ын буцаан олголт, сугалааны урамшуулалд зарцуулсан 38.7 тэрбум төгрөгийг 2016 онд өмнөх оноос нэмэгдсэн НӨАТ-ын орлоготой харьцуулбал 2.21 дахин өгөөж бий болгосон буюу 1 төгрөгийн зардал гаргаж, 2 төгрөг 21 мөнгөний ахиу орлогыг олсон байна.
- Томоохон зах, худалдааны төвүүдийн худалдаа, үйлчилгээний газруудад худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа татвар төлөгчдийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг НӨАТУС-д бүртгэх ажил хангалтгүй байгаа нь НӨАТ-ын буцаан олголтын зорилго бүрэн биелээгүйг илтгэж байна.
- Татварын алба АТСТ бүр илүү төлсөн НӨАТ-ыг буцаан авах хүсэлт гаргах боломжийг бүрдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, НӨАТУС-тэй уялдуулах замаар илүү төлөлтийг хянаж, баталгаажуулах ажлыг шуурхай, хуулийн хугацаанд багтаан гүйцэтгэх шаардлагатай байна.
- НӨАТУС-ийн өртгийг бүрэн тодорхойлоогүй, төрийн өмчийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, зохиогчийн эрхийг баталгаажуулаагүйгээс өмч, хөрөнгөд эрсдэл гарч болзошгүй байна.
- Нэмэгдсэн өртгийн албан татварын бодлогын хэрэгжилт, үр дүнг сайжруулахын тулд НӨАТ төлөгч биш татвар төлөгчийг НӨАТУС-д бүртгэх, борлуулалтын мэдээллийг НӨАТУС-д илгээгээгүй АТСТ-д хариуцлага ногдуулдаг болгох замаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.
- Албан татвар төлөгчид худалдан авалтын мэдээллийг, АТСТ нар борлуулалтын мэдээллийг НӨАТУС-д илгээж, баталгаажуулахгүй байгаа нь Татварын албанаас явуулж байгаа сургалт сурталчилгааны үр дүн, хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.
- Албан татвар төлөгчийн худалдан авалтын төлбөрийн баримтыг НӨАТУС-д автоматаар бүртгэх техник технологийн хөгжүүлэлт хийх шаардлагатай байна.
- Монгол банк дахь буцаан олголтын тусгай дансны 461.3 сая төгрөгийн үлдэгдлийг холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх талаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.
- НӨАТ-ын урамшуулал олголтын эрсдэлийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож, хянах аргачлалыг сайжруулах шаардлагатай байна.
- Сангийн яамны харьяа Гааль, татвар санхүүгийн мэдээллийн технологийн төвд бүртгэлтэй ПОС машин нийлүүлэгч компанийн тоо 2017 оны байдлаар 64 байгаа бөгөөд улсын хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг бүртгэх, хэрхэн хянах талаар эрх зүйн зохицуулалтгүй байна.



- Маргаан таслах зөвлөл гомдлыг шийдвэрлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримтлахгүй байна.
- Үндэслэлгүй акт тогтоосон татварын улсын байцаагчдад Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй уялдуулан хариуцлага тооцох ажил огт хийгдэж ирээгүй байна.
- Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаа бие даасан, хараат бус, бусдын нөлөөнд үл автах зарчим алдагдах эрсдэлтэй байна.
- Дотоод хяналтыг холбогдох журам, зохицуулалтад нийцүүлэн хэрэгжүүлээгүй, Нэмэгдсэн өртгийн буцаан олголтод Сангийн яамнаас тавих хяналт хангалтгүй байна.



Зөвлөмж

Аудитаар илрүүлсэн зөрчил, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Сангийн сайдад:

1. Сангийн яамны НӨАТ-ын буцаан олголтод тавих хяналтыг сайжруулж, түүний үр дүнг тооцож ажиллах.
2. Нэмэгдсэн өртгийн албан татварын бодлогыг хэрэгжүүлэх зорилгыг хангаж, холбогдох хууль, журамд дараах асуудлыг тусгах боломжийг судалж хэрэгжүүлэх. Үүнд:
 - ✓ Том татвар төлөгчийн НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг дахин хянаж, баталгаажуулах;
 - ✓ НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хугацааг шалгалтын хамрах хугацаа, албан татвар суутган төлөгчийн үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан үндэслэлтэй тогтоох;
 - ✓ НӨАТ-ын илүү төлөлттэй АТСТ бүр илүү төлсөн НӨАТ-ыг буцаан авах хүсэлт гаргах боломжийг бүрдүүлэх;
 - ✓ Албан татвар суутган төлөгч нарын илүү төлсөн НӨАТ-ын буцаан олголтын хувь хэмжээг бууруулах, төсөвт төлсөн татварын 30 хувиас хэтрүүлэхгүй, салбарын ангиллаар олгох;
 - ✓ Томоохон зах, худалдааны төвүүдийн худалдаа, үйлчилгээний газруудад худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа татвар төлөгчдийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг НӨАТУС-д бүртгэх ажлыг Засгийн газрын бусад чиг үүргийн яамдын харьяа бүх шатны хууль, хяналтын болон нутгийн захиргааны байгууллагыг оролцуулан нутаг дэвсгэрийн хэмжээнд шуурхай зохион байгуулах;
 - ✓ Нийгмийн хариуцлагын хүрээнд томоохон зах, худалдааны төвийн түрээслүүлэгч компаниудад бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг НӨАТУС-т бүртгүүлэхийг үүрэг болгох;
 - ✓ Борлуулалтын орлогын хэмжээ 50.0 сая төгрөгт хүрээгүй буюу АТСТ биш этгээд нь заавал хэрэглэгчийн системтэй байх шаардлагыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд шинээр тусгах;
 - ✓ Борлуулалтын мэдээллээ холбогдох журамд заасан хугацаанд НӨАТУС-д илгээгээгүй татвар төлөгчид хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
 - ✓ Олон улсад татварын урамшууллын системийг амжилттай хэрэгжүүлсэн сайн туршлагын дагуу НӨАТУС-д худалдан авалтын мэдээлэл автоматаар шивэгдэх, техник, технологийн хөгжүүлэлт хийх;
 - ✓ Албан татвар төлөгчдийн 2016 оны худалдан авалтад төлсөн НӨАТ-ын буцаан олголтыг бүрэн олгоогүйгээс тусгай дансанд байршиж байгаа хуримтлагдсан үлдэгдлийг тодорхой давтамжаар улсын төсөвт төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлыг судалж шийдвэрлэх;
 - ✓ ПОС машин нийлүүлэгч компаниудыг бүртгэлжүүлэх, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлсэн төрийн зохицуулалтыг ойрын хугацаанд бий болгох.
3. Татварын маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дор дурдсан асуудлыг судалж, холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулж, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах. Үүнд:
 - ✓ Татварын албаны дэргэдэх МТЗ-ийг Сангийн яамны дэргэдэх Маргаан таслах зөвлөл, аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн дэргэдэх МТЗ-ийг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Маргаан таслах зөвлөл болгон өөрчлөн зохион байгуулах;
 - ✓ Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6, 27.6.8, 42 дугаар зүйлийн 42.3, 42.8, Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ын 3.2 дах заалтад нэмэлт, өөрчлөлт оруулан Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн, магадлагчид тавих шалгуурыг нэмэгдүүлэх,



- ✓ Татварын асуудлаар үүссэн маргаан “Захиргааны хэргийн шүүх” болон МТЗ-өөр шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд татварын улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөл зохих нөхөн төлбөрийн дүнд зохих хэмжээний алданги, торгууль тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
 - ✓ Маргаан таслах зөвлөл татвар төлөгчийн гомдлыг хүлээн авахдаа татварын улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөл зохих нөхөн төлбөрийн тодорхой хувийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
 - ✓ Маргаан таслах зөвлөлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг бодитойгоор тогтоож, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах;
 - ✓ Татварын улсын байцаагч нар Маргаан таслах зөвлөлийн шийдвэрт гомдолтой байгаа тохиолдолд шүүхэд хандах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох.
4. НӨАТУС-ийн өртгийг бүрэн, бодитой тодорхойлж, шаардлагатай бол зохиогчийн эрхийг баталгаажуулан, төрийн өмчийг НББ, тайланд зохих ёсоор тусгах.

Татварын ерөнхий газрын даргад:

1. Хамаарал бүхий этгээдүүд, групп компаниудын НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах шалгалтыг иж бүрнээр хийж байх;
2. Дор дурдсан компаниудын НӨАТ-ын баталгаажуулах шалгалтыг иж бүрнээр буюу групп компаниудыг бүгдийг нь хамруулан дахин хийж, үр дүнг ҮАГ-т ирүүлэх;
 - Энержи ресурс ХХК
 - Тавантолгой транс ХХК
 - Витафит инвест ХХК
 - Ар Ди си си ХХК
3. НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийн баталгаажуулалтын актын загварыг өөрчлөх;
4. НӨАТ-ын урамшуулал олголтын эрсдэлийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож, хянах аргачлалыг сайжруулах;
5. НӨАТУС-ийн талаар иргэдэд хүргэх сурталчилгаа, мэдээллийг үр дүнтэй, хүртээмжтэй арга хэлбэрээр зохион байгуулах.

Татварын албаны дэргэдэх татварын “Маргаан таслах зөвлөл”-д:

1. Татварын ерөнхий газрын дэргэдэх “Маргаан таслах зөвлөл”-д ирүүлсэн гомдлыг хууль, журамд заасан хугацаанд шийдвэрлэх,
2. “Маргаан таслах зөвлөл”-өөс Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.6-д “Татварын акт, дүгнэлт хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдвол түүнийг бичсэн татварын улсын байцаагчид Татварын ерөнхий хуулийн 73.2-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг Татварын ерөнхий газрын даргад тавих” гэж заасны дагуу татварын улсын байцаагчид хариуцлага тооцох саналыг гаргаж хэвших.



Тайлангийн төсөлд Сангийн яамнаас ирүүлсэн санал


МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
15180 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-74-68, <http://www.mof.gov.mn>

№ 4-2/6613
төний _____ -ны № 01/1646 -г

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Д.ХҮРЭЛБААТАР
ТАНАА**

Танай 2017 оны 01/1646 тоот албан бичгээр ирүүлсэн "Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 1 хуудастай

Хүндэтгэсэн,




Ч.ХҮРЭЛБААТАР

1950



Тайлбарын дугаар		Тайлангийн төсөлд ирүүлсэн санал, тайлбар
Тайлбар №1-г үзнэ үү	1.3-т “НӨАТ-ын бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна” гэжээ. Үүний шалтгаан нь Сангийн яам, Татварын ерөнхий газар нь НӨАТ буцаан олголтод баримтлах бодлогын баримт бичиг батлаагүй, хуулийн хэрэгжилтийг хангах урт болон дунд хугацааны стратегийн баримт бичиг батлаагүй гэжээ. Гэвч, НӨАТ нь зөвхөн Сангийн яам, гааль, татварын албаны хэмжээнд хэрэгжих хууль биш учир тус хуулийг хэрэгжүүлэх асуудлаар Сангийн яамнаас бие даан шийдвэр гаргах боломжгүй юм.	
Тайлбар №2-г үзнэ үү	1.26-д НӨАТ-ын борлуулалтын мэдээллийг илгээгээгүй тохиолдолд тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна гэжээ. Гэвч, Зөрчлийн хуулийн 11.19 дүгээр зүйлийн “13.Хуульд тодорхойлсон аливаа системийг зохисгүй ашигласан, эсхүл албаны чиг үүрэгт хамаарах зорилгоос гадуур хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсний дагуу дээрх зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээхээр байна. Учир нь иргэнд холбогдох баримтыг өгсөн боловч борлуулалтын мэдээллээ илгээгээгүй нь “Хуульд тодорхойлсон аливаа системийг зохисгүй ашигласан” зөрчилд хамаарахаар байна.	
Тайлбар №3-г үзнэ үү	1.28-д НӨАТУС-аас хэвлэгдсэн баримтын бүртгэл бүрэн хийгдэхгүй байгаа нь дараах шалтгаантай байгааг нэмж бичих нь зүйтэй байна. Үүнд: 1. Хуулийн этгээд хэвлэгдсэн баримтын бүртгэлийг илгээхгүй байгаа. Энэ зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээж байна. 2. Иргэн өөрийн баримтыг бүртгүүлэхгүй байх. Энэ нь уг этгээд буцаан олголт авах, сугалаанд оролцох боломжоо алдаж байгаа юм. 3. Иргэн баримтын мэдээллээ зөрүүтэй бүртгүүлэх явдал байна.	
Тайлбар №4-г үзнэ үү	1.30. НӨАТ-ын буцаан олголт нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу жилд нэг удаа хийгдэх зохицуулалттай бөгөөд энэхүү давтамжийг өөрчлөхийн тулд тус хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болно.	
Тайлбар №5-г үзнэ үү	1.37, 1.38, 1.39-д заасны дагуу хэрэв бизнесийн үйл ажиллагаа явуулдаг иргэний жилийн борлуулалтын орлого нь 50 сая төгрөг буюу түүнээс дээш болох тохиолдолд уг этгээд нь нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч болно. Энэ тохиолдолд худалдан авалтад төлсөн албан татвараасаа борлуулалтад төлөх татвараа хасуулах замаар татварын ямар нэг дарамт үүрэхгүй юм. Харин түүний оронд НӨАТ-тай худалдан авалтаа хасуулахгүйгээр буцаан олголт авах нь тухайн этгээдэд ашиггүй болно. Тодруулбал, 1000 төгрөгийн үнэтэй барааг 100 төгрөгийн НӨАТ-тай үнээр худалдан авч, төсөвт 100 төгрөгийг төлнө. Үүнд өөрийн ашгийг нэмээд тухайн барааг 2000 төгрөг болгоод борлуулахад иргэнээс 200 төгрөгийн татвар суутган авч төсөвт төлөх ёстой бөгөөд энэ тохиолдолд өөрийн худалдан авалтад төлсөн 100 төгрөгийн татвараа хасч 100 төгрөгийн татварыг суутган авч төсөвт төлөхөөр байна. Харин энэ зарчмыг дагалгүй өөрөө эцсийн хэрэглэгч болсон тохиолдолд худалдан авалтдаа төлсөн 100 төгрөгийн татвараа буцаан авах боломжгүй болж, ийнхүү төлсөн 100 төгрөгийн татварынхаа 20 төгрөгийг л буцаан авах боломжтой болно. Энэ нь бизнес эрхлэгчийн хувьд сонгох сонголт биш юм.	
Тайлбар №6-г үзнэ үү	Тайлангийн төсөлд дурдагдсан зарим тоон мэдээлэл, он сард өөрчлөлт оруулах талаар: Тайлангийн төслийн 6-р хуудасны хамгийн сүүлийн догол мөрд дурдагдсан тоон баримтын хувьд сугалааны тохирол нь “18” биш “19” удаа зохион байгуулагдсан бөгөөд нийт “82.5 мянган” азтан биш “86.2 мянган” азтанд “3.7 тэрбум төгрөгийг хонжвор” биш “3.6 тэрбум төгрөгийн хонжвор” таарсан байна. Тайлангийн төслийн 7-р хуудасны Хүснэгт 2-ын мэдээлэлд 2015 оны ААНОАТ-ын гүйцэтгэл “698.8 тэрбум төгрөг” биш “688.5 тэрбум төгрөг” болно. Түүний эх сурвалж болох тус яамнаас хүргүүлсэн албан бичиг нь “2017 оны 4-2/3796” биш “2017 оны 4-2/3769” гэсэн албан бичгээр зөвхөн НӨАТ-ын орлогын мэдээг хүргүүлсэн байна. Тайлангийн төслийн 1.7, 1.25, 1.31, 1.34, 1.38, 2.14-т заасан “Сангийн сайдын 2016 оны 333 дугаар тушаал” гэснийг “Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаал” гэж өөрчлөх. Учир нь холбогдох журам нь 2015 онд батлагдсан болно.	
Тайлбар №7-г үзнэ үү	Маргаан таслах зөвлөл нь хуулийн хүрээнд ажиллахгүй байгаа талаар дурдахдаа хэрэг маргааныг шийдвэрлэсэн хугацааг тооцсон байна. Татварын ерөнхий хуулийн 72.3.Татварын алба болон Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 72.1-д заасны дагуу гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхдээ энэ хууль, Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Маргааны таслах зөвлөлийн ажиллах журмыг дагаж мөрдөнө. гэж заасны дагуу маргааныг 30 хоногийн хугацаанд болон шаардлагатай тохиолдолд уг хугацааг 30 хоногоор сунгах нөхцөлтэйгөөр шийдвэрлэдэг. Гэвч, уг маргаанд оролцогч талуудын хүсэлт болон хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг шалгах, шийдвэр гаргахад тодруулга авах зорилгоор уг хуулиар тогтоосон хугацаа сунгагддаг бөгөөд энэ нь зөрчил биш талуудын хүсэлтийг шийдвэрлэх нөхцөл юм.	



	Тайлангийн төслийн 2.5-д заасан асуудал шийдвэрлэх хугацаа нь хэргийг шийдвэрлэхэд ямар ч саадгүй, асуудлыг үнэн зөв бодитоор дүгнэх боломжтой үед хийгддэг зохицуулалт юм. Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаа нь татвар төлөгчийн гомдлоор хэрэг үүсгэж, татвар төлөгчийн гэм бурууг тогтоодог бөгөөд энэхүү шийдвэрийн үр дүнд татвар төлөгчид эрүүгийн хэрэг үүсгэх боломжтой дүгнэлтийг ч батлах боломжтой байдаг. Энэ агуулгаар хэргийн үнэн зөвийг бодитоор тогтоох зайлшгүй шаардлагыг харгалзан хэргийг тал бүрээс нь судалж, улмаар тэрхүү акт, дүгнэлтийг өөрчлөх, хүчингүй болгох эсхүл хэвээр үлдээх томоохон эрх зүйн үр дагаврыг бий болгодог. Энэ зорилгоор хэргийн оролцогчдын хүсэлтээр уг 30 хоногийн хугацаа нь тасалдах бүрэн боломжтой юм. Өөрөөр хэлбэл, энэхүү судалгаанд авагдсан хугацаа хэтрүүлсэн тоо нь хэргийн оролцогчийн хүсэлтээр хэрэг хянан шийдвэрлэх явцад хугацаа түр зогссон үйлдэлд хамаардаг. Иймд цаашид энэхүү хугацааг хуулиар илүү урт байхаар нарийвчлан тогтоох шаардлагатай байгаа юм. Учир нь өнгөрсөн 5 хүртэлх жилийн хугацааны татварын нөхөн ногдуулалтыг дахин магадлахад хугацаа шаардлагатай юм.
Тайлбар №8-г үзнэ үү	2.7-2.10-т заасан дүгнэлтийн хувьд: Захиргааны ерөнхий хуулийн 105.2-т заасны дагуу зөрчил гаргасан татварын улсын байцаагчид хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт 2016 оны 7 дугаар сарын 1-ээс бий болсон бөгөөд энэ тохиолдолд тухайн байцаагчийг томилсон албан тушаалтан нь хариуцлага хүлээлгэхээр байна.
Тайлбар №9-г үзнэ үү	2.11, 2.12-т заасны дагуу маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг Татварын ерөнхий газрын дарга батлах нь Захиргааны ерөнхий хуультай нийцэхгүй байгаа бөгөөд цаашид энэхүү хуулийн заалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага үүсч байна.
Тайлбар №10-г үзнэ үү	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль нь 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр шинэчлэн батлагдаж, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, иргэнд буцаан олгох, сугалааны тохирлоор урамшуулал олгодог эрх зүйн зохицуулалт нь 2016 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлж байгаа болно.
Тайлбар №11-г үзнэ үү	Зөвлөмж хэсэгт: Томоохон зах, худалдааны төвийг НӨАТУС-т холбох, бүртгэх ажиллагааг Сангийн яам биш хуулийг хэрэгжүүлэгч Татварын ерөнхий газарт даалгах нь зүйтэй.
Тайлбар №12-г үзнэ үү	Зөвлөмж хэсэгт: Борлуулалтын орлогын хэмжээ 50 сая төгрөгт хүрээгүй татвар төлөгчийг хэрэглэгчийн системд бүртгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлыг хуульчлах гэснийг зөвлөмжөөс хасах. Учир нь Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8. татвар төлөгч нь Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх гэж заасан бөгөөд энэхүү стандартын шаардлага гэдэг нь хэрэглэгчийн системд холбогдсон кассын машиныг хэрэглэхийг заасан болно.
Тайлбар №13-г үзнэ үү	Зөвлөмж хэсэгт: Борлуулалтын мэдээллээ хуульд заасан хугацаанд илгээгээгүй татвар төлөгчид хариуцлага хүлээлгэх гэснийг хасах. Учир нь Зөрчлийн хуулийн 11.19 дүгээр зүйлийн “13.Хуульд тодорхойлсон аливаа системийг зохисгүй ашигласан, эсхүл албаны чиг үүрэгт хамаарах зорилгоос гадуур хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсний дагуу хариуцлага хүлээхээр байна
Тайлбар №14-г үзнэ үү	Иргэдийн 2016 оны худалдан авалтад төлсөн НӨАТ нь 2017 онд олгогддог. Энэ агуулгаар 2017 оны төсөвт туссан НӨАТ-ыг буцаан татах боломжгүй бөгөөд энэ нь 2017 оны төсвийн бүрэлдэхүүн хэсэг юм. 2017 оны төсөв нь 2017 оны 12 сарын 31-ээр тасалбар болон хаагдаж, улсын төсөвт төвлөрдөг. Иймд дээрх зөвлөмжийг хасах.
Тайлбар №15-г үзнэ үү	Татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөлийг Сангийн яамны дэргэд, аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөлийг аймаг, нийслэлийн засаг даргын дэргэдэх гэж өөрчлөх зөвлөмж нь Захиргааны ерөнхий хуулийн зарчимтай нийцэхгүй байна. Учир нь маргаан таслах зөвлөл бол татварын албаны шийдвэрийг өөрчлөх түүний дээд шатны байгууллага тул үүнийг нутгийн захиргааны байгууллагын доор болгон өөрчлөх нь үндэслэлгүй байна. Харин энэхүү маргаан таслах зөвлөл нь зөвхөн 1 шатлалаар хэргийг шийдвэрлэн, түүний гаргасан шийдвэрийг дээд шатны татварын албаны дарга баталгаажуулдаг байдлыг өөрчилж, маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг шууд шүүхэд ханддаг байдлаар өөрчлөх нь хүнд суртал шат дарааллыг бууруулж, Захиргааны ерөнхий хуулийн зарчимтай нийцэхээр байна.
Тайлбар №16-г үзнэ үү	Мөн маргаан таслах зөвлөлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг бодитойгоор тогтоож, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах гэсэн шинэ зөвлөмж нэмэх саналтай байна.



Сангийн яамнаас ирүүлсэн саналд өгөх Үндэсний аудитын газрын тайлбар

Сангийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

1. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлд Сангийн сайд нь Татварын бодлогын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхлэх үүрэгтэй болохыг тодохойлсон байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
2. Аудитын хамрах хүрээнд Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхлээгүй байсан тул тус саналыг хүлээн авах боломжгүй байна.
3. Саналыг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг хийлээ.
4. Өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.
5. Өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.
6. а) Тоо мэдээ зөрүүтэй байсныг тулгаж засварлав.
б) Ирүүлсэн тайлбар үндэслэлгүй учир өөрчлөх шаардлагагүй.
в) Тайлангийн төслийн 1.25, 1.31, 1.34, 1.38, 2.14-т заасан журмын баталсан оныг 2015 болгон засав.
7. Саналыг хүлээн авах боломжгүй.
8. Саналыг хүлээн авах боломжгүй.
9. Тайлангийн төсөлд бичсэн санааг дэмжсэн нэмэлт тодруулга тул тайлангийн төсөлд тусгах шаардлагагүй.
10. Нэмэлт тодруулга тул тайлангийн төсөлд тусгах шаардлагагүй.
11. Өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.
12. Өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно. /Хуулийг тайлбарлаж болохгүй/
13. Аудитын хамрах хугацаанд Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхлээгүй байсан цаашид Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэж болох эсэхийг судлаж шийдвэрлэх шаардлагатай тул саналыг хүлээн авах боломжгүй.
14. Өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.
15. Хуулийн хэлтсийн саналыг харгалзан саналыг хүлээн авах эсэхийг шийдэх нь зүйтэй.
16. Маргаан таслах зөвлөлийн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг бодитойгоор тогтоож, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах гэсэн саналыг хүлээн авч Сангийн сайдад өгөх зөвлөмжид нэмлээ.



Татварын ерөнхий газраас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
15100 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж, Утас/Факс: (976-11) 32 13 09,
E-mail: info@mta.mn

2017.11.15 № 01/3205

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

“Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр, дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ...³ хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Д.ЗАНДАНБАТ



ХАВСРАЛТ



Тайлбарын дугаар	ТЕГ-аас тайлангийн төсөлд ирүүлсэн санал, тайлбар
Тайлбар №1-г үзнэ үү	1.3-т “... Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг урт болон дунд хугацааны стратегийн болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд нарийвчлан тусгаагүй ...” байна гэсэн дүгнэлтэд дараах тайлбарыг гаргаж байна. Сангийн Яам, Татварын ерөнхий газраас шинэчилэн найруулсан нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хуулийг хэрэгжүүлэх, хуульд заасан буцаан олголт, урамшууллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлогын баримт бичиг болох аргачлал, заавар, журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Мөн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавихад шаардлагатай програм хангамжийг боловсруулан нэвтрүүлж улмаар улсын хэмжээнд хуулийн хэрэгжилтийг хангах шат дараалсан үйл ажиллагааны болон тусгай ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал: Хуулийн өөрчлөлтийн үндсэн концепци болох Нэмэгдсэн өртгийн албан татварын татвар төлөгч (эцсийн хэрэглэгч, худалдан авагч)-ийн оролцоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих замаар хууль, тогтоомжийн мөрдөлтийг сайжруулах, далд эдийн засгийг бууруулах, татварын орлогыг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн ажлыг Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны (4 жил) төлөвлөгөөнд (Татварын эрх зүйн орчинг шинэчлэх боловсронгуй болгох, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх арга зүйг сайжруулах зорилтийн хүрээнд хийх ажил)-нд тусгасан.
Тайлбар №2-г үзнэ үү	Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг татварын албаны хэмжээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийн зэрэгцээ Татварын ерөнхий газрын даргын тушаалаар улсын хэмжээнд Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тусгай ажлын төлөвлөгөө, гарган хэрэгжилтэнд сар бүр Хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг тооцон ажиллаж байна.
Тайлбар №3-г үзнэ үү	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан татвар төлөгчид урамшуулал, албан татварын буцаан олгох ажлыг зохион байгуулахдаа Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам, Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох журам, Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журмыг Сангийн Сайдын тушаалаар батлуулан, мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Боловсруулан батлуулсан эрх зүйн баримт бичгийг Хавсралт-2-аас үзнэ үү. Дээрх хууль, журмыг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад шаардлагатай систем, програм хангамжийг хөгжүүлж, нэвтрүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.
Тайлбар №4-г үзнэ үү	1.6-д “... 2016 онд өмнөх оноос нэмэгдсэн НӨАТ-ын орлоготой харьцуулбал 2.21 дахин өгөөж бий болгосон буюу 1 төгрөгийн зардал гаргаж, 2 төгрөг 21 мөнгөний ахиу орлогыг олсон байна.” гэх дүгнэлтэд дараах тайлбарыг гаргаж байна. Үүнд: Нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг 50.0 сая төгрөг болгон 5 дахин нэмэгдүүлсэн, улмаар орлогын гүйцэтгэлд импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын дүн орсон, дотоодын бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын ногдлын өсөлт болон нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг нэвтрүүлснээр эцсийн хэрэглээний худалдан авалтын мэдээлэл цуглуулан хяналт тавих замаар далд эдийн засгийн хэмжээг бууруулсан, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, онцгой албан татварын зэрэг бусад татварын орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн эерэг нөлөөлөл, өсөлт зэргийг тооцолгүйгээр ахиуц орлогыг тодорхойлсон учраас өрөөсгөл гэж үзэж байна;
Тайлбар №5-г үзнэ үү	1.7-д дурдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системд холбогдоогүй 3’711 албан татвар суутган төлөгч нь хэдийгээр хуулийн шаардлага ханган суутган төлөгчөөр бүртгүүлсэн боловч үйл ажиллагаа эрхлээгүй, санхүүгийн хүндрэлээс түр хугацаанд үйл ажиллагаа нь зогсон улмаар “х” тайлан гаргасан идэвхгүй татвар төлөгч байх тул шууд утгаар Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль тогтоомжийг зөрчсөн гэж дүгнэх боломжгүй;
Тайлбар №6-г үзнэ үү	1.8-д дурдсан “Татварын алба АТСТ-г НӨАТУС-д бүрэн хамруулах ажлыг хангалтгүй хэрэгжүүлж байгаагаас ...” гэдэг нь бодит байдалтай нийлэхгүй байна. Татварын алба 2017 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар бүртгэгдвэл зохих албан татвар суутган төлөгчийн 88.69 хувийг, 09 дүгээр сарын 30-ны байдлаар 92.09 хувийг НӨАТУС-ийн нэгдсэн системд бүртгэсэн байна.
Тайлбар №7-г үзнэ үү	1.26 “... мэдээллийг илгээгүй зөрчилд хариуцлага тооцох эрхзүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалж байна.” гэх дүгнэлтэд дараах тайлбарыг гаргаж байна. Үүнд: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.2.3 заалт, Сангийн сайдын 2017 оны 37 дугаар тушаалаар баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох журмын 5.2 заалт, Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгох журмын 3.3.3 заалт, Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 11.1 заалтыг тус тус үндэслэн борлуулалтын мэдээллээ илгээгээгүй татвар төлөгчид хариуцлага тооцох хуулийн зохицуулалттай байна.



Тайлбар №8-г үзнэ үү	Төслийн 1.23 “... 50.0 сая төгрөгт хүрээгүй буюу АТСТ биш 184815 иргэн, ... НӨАТУС-д бүртгэх шаардлагыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт байхгүй ...” гэсэн дүгнэлтэд тусгагдсан тоон мэдээлэл болон агуулгын хувьд үндэслэл муутай байна.
Тайлбар №9-г үзнэ үү	1.25 “... борлуулалтын мэдээллийг НӨАТУС-д илгээгүй байна.” гэсэн байна. АТСТ-ийн илгээгээгүй төлөвт шилжсэн баримтыг нөхөн илгээхэд нэгдсэн систем автоматаар баталгаажсан болон бусад төлөвт шилждэг.
Тайлбар №10-г үзнэ үү	Хүснэгт 2. “Зарим татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн судалгаа”-ны ААНОАТ-ын болон ХХОАТ-ын орлогын зарим тоон мэдээлэл Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн тоон мэдээллээс зөрүүтэй байгааг залруулах.-Эх үүсвэр сангийн яамны тоо
Тайлбар №11-г үзнэ үү	Төслийн хоёрдугаар бүлгийн 2.10-т “... ТЕГ-ын дэргэдэх МТЗ 2015-2016 онд нийт 165 гомдол шийдвэрлэснээс 54.5 хувь нь буюу 90 нь Захиргааны хэргийн шүүхэд тус зөвлөлийн шийдвэрт гомдол гаргасан байх бөгөөд тус шүүх нийт 26 гомдолд холбогдох 101,263.0 сая төгрөгийн ТУБ-ийн актыг хүчингүй болгож, татвар төлөгчийн талд шийдвэр гаргасан байна.” байна гэсэн дүгнэлтэд дараах тайлбарыг гаргаж байна. Захиргааны хэргийн шүүхэд татвар төлөгч Маргаан таслах зөвлөлийн шийдвэрт гомдол гаргахгүй бөгөөд татварын улсын байцаагчийн актаар тогтоосон захиргааны шийдвэрт нэхэмжлэл гаргадаг. Захиргааны хэргийн шүүх 2015, 2016 онд нийт 26 гомдолд холбогдох 101,263.0 сая төгрөгийн Татварын улсын байцаагчийн актыг хүчингүй болгож, татвар төлөгчийн талд шийдвэрлэсэн нь дараах байдалтай байна. Үүнд: нийт хүчингүй болгон шийдвэрлэсэн дүнгийн 97.9 хувь буюу 99,196.5 сая төгрөгийн шийдвэр нь 3 татвар төлөгчтэй холбоотой байна.
Тайлбар №12-г үзнэ үү	Дүгнэлт хэсэгт: “Томоохон зах, худалдааны төвүүдийн худалдаа үйлчилгээний газруудад худалдаа үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгчдийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг НӨАТУС-д бүртгэх ажил хангалтгүй байгаа нь НӨАТ-ын буцаан олголтын зорилго бүрэн биелээгүйг илтгэж байна.” гэх дүгнэлтийг “ Хэдийгээр Татварын алба, орон нутгийн төр захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран төвлөрсөн зах, худалдааны төвд худалдаа, ажил, үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгч хувь хүн хуулийн этгээдийг НӨАТУС-д холбох ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа боловч ажлын үр дүн нь зорилтот түвшинд хүрээгүй, цаашид эрчимжүүлэх шаардлагатай байна.” гэж өөрчлөх;
Тайлбар №13-г үзнэ үү	Дүгнэлт хэсэгт: “ НӨАТУС-ийн өртгийг бүрэн тодорхойлоогүй ... эрсдэл гарч болзошгүй байна.” гэх дүгнэлтийг “НӨАТУС-ийн төслийн нэгжийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, програм хангамжийн үнэ өртгийг тодорхойлсон аргачлал тодорхойгүйн улмаас НӨАТУС-ийг ТЕГ-ын санхүүгийн тайлан, бүртгэлд тусгаагүй байна.” гэж өөрчлөх;-Авахгүй
Тайлбар №14-г үзнэ үү	Зөвлөмж хэсэгт: “Томоохон зах, худалдааны төвүүдийн худалдаа, үйлчилгээний газруудад худалдаа, үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгчдийн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг НӨАТУС-д бүртгэх ажлыг шуурхай зохион байгуулах” –үүн дээр “ЗГ-ын бусад чиг үүргийн яамдын харьяа бүх шатны хууль хяналтын болон захиргааны байгууллагыг оролцуулан нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн зохион байгуулах арга хэмжээ авах” гэж нэмэх /Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн ерөнхий газар, бүх түвшиний Засаг дарга/
Тайлбар №15-г үзнэ үү	Төслийн Сангийн Сайдад өгсөн 2, 3 дахь зөвлөмжийг энэхүү саналын 6-д заасан тайлбартай нийцүүлэх;
Тайлбар №16-г үзнэ үү	НӨАТУС систем, програм, хангамж нь “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ-ын өмчлөлд байгаа тул төслийн ТЕГ-ын даргад өгсөн “... төрийн өмчийг НББ, тайланд зохих ёсоор тусгах” гэсэн зөвлөмжийг Сангийн Сайдад өгсөн зөвлөмжийн хэсэгт оруулах;



ТЕГ-ын ирүүлсэн саналд өгөх Үндэсний аудитын газрын тайлбар

Татварын Ерөнхий Газраас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

1. Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны (4 жил) төлөвлөгөөг аудитын явцад гаргаж өгөөгүй тул тайлбарыг хүлээн авах боломжгүй.
2. ТЕГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтцийн хөтөлбөрт НӨАТ-ын талаар баримтлах бодлогыг тусгаж өгөөгүй байсан тул тайлбарыг хүлээн авах боломжгүй.
3. Аудитын явцад НӨАТ-ын талаарх хууль, эрх зүйн жагсаалтыг гаргаж өгөхийг шаардсан боловч гаргаж өгөөгүй тул тайлбарыг хүлээн авах боломжгүй.
4. НӨАТ-ын Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого болон зарлагад үндэслэн тооцооллыг хийсэн тул өөрчлөлт хийх шаардлагагүй.
5. Албан татвар суутган төлөгч нь үйл ажиллагаа явуулаагүй улмаар Х тайлан гаргасан тохиолдолд НӨАТУС-д бүртгүүлэхгүй байж болох талаар хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй тул саналыг хүлээж авах боломжгүй.
6. Саналыг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг хийлээ.
7. Аудитын хамрах хүрээнд Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхлээгүй байсан тул тус саналыг хүлээн авах боломжгүй байна.
8. ТЕГ-аас ирүүлсэн тоо мэдээлэл үндэслэсэн учир өөрчлөлт хийх шаардлагагүй.
9. Ирүүлсэн тайлбарт үндэслэн өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзлээ.
10. Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэсэн болно.
11. Ирүүлсэн саналыг үндэслэн тайлангийн төсөлд зохих өөрчлөлтийг оруулав.
12. Нэмэлт тодруулгыг хийж, судалж үзэх шаардлагатай.
13. Саналыг хүлээн авах боломжгүй.
14. Саналыг хүлээн авч зөвлөмжид тусгалаа.
15. Саналыг хүлээн авч зөвлөмжид нэмж тусгалаа.
16. Сангийн сайдад өгөх зөвлөмжийн хэсэгт оруулж, өөрчлөв.



Хавсралтууд

Хавсралт № 1

Борлуулалтын орлогод “0” /тэг/ хувь ногдуулж, НӨАТ-ын буцаалт авсан АТСТ нарын судалгаа

(сая төгрөгөөр)

Татвар төлөгчийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хамрах хугацаа	Борлуулалтын орлого	Тухайн хугацааны тэг “0” хувьтай борлуулалт	Тухайн хугацааны НӨАТ ногдох борлуулалт	Ногдуулсан НӨАТ	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн НӨАТ	Буцаан авах НӨАТ
1	2	3	4 (5+6)	5	6	8 (6*10%)	9	10 (9-8)
МИАТ ХК	Агаарын тээвэр	2014.10.01- 2014.12.31	61,271.2	56,939.8	4,331.4	433.1	651.5	218.4
МИАТ ХК	Агаарын тээвэр	2015.01.01- 2015.09.30	193,874.7	183,586.4	10,288.3	1,028.8	2,077.2	1,048.4
МИАТ ХК	Агаарын тээвэр	2015.10.01- 2015.12.31	52,404.7	46,662.0	5,742.6	574.3	780.7	206.5
Нийт буцаан олголт								1,473.3
Энержи ресурс ХХК	Экспорт	2014.06.01- 2015.01.31	400,920.1	221,455.8	179,448.3	17,944.8	47,222.0	29,120.5
Энержи ресурс ХХК	Экспорт	2015.02.01- 2015.06.30	99,242.6	78,806.7	20,435.9	2,043.6	10,255.9	8,212.3
Энержи ресурс ХХК	Экспорт	2015.07.01- 2015.09.30	44,611.8	42,165.6	2,446.2	244.6	4,590.1	4,339.5
Энержи ресурс ХХК	Экспорт	2015.10.01- 2015.12.31	37,871.4	4,675.2	33,196.3	3,319.6	9,291.0	5,971.4
Энержи ресурс ХХК	Экспорт	2016.01.01- 2016.08.31	87,189.2	77,652.2	8,782.6	878.3	5,761.7	4,883.4
Нийт буцаан олголт								52,527.1
Шим технологжи ХХК	Экспорт	2015.04.01- 2015.09.30	15,785.9	15,766.3	19.6	2.0	1,859.4	1,857.4
Шим технологжи ХХК	Экспорт	2015.10.01- 2015.12.31	2,450.7	2,450.5	0.2	0.024	563.0	563.0
Шим технологжи ХХК	Экспорт	2016.01.01- 2016.03.31	1,905.0	1,904.3	0.7	0.067	152.0	151.9
Шим технологжи ХХК	Экспорт	2016.04.01- 2016.06.30	2,510.8	2,510.5	0.4	0.037	235.9	235.9
Нийт буцаан олголт								2,808.2
Ачит-Ихт ХХК	Экспорт	2011.02.09- 2014.12.31	56,229.4	55,154.8	1.6	0.2	5,251.0	5,143.5
Ачит-Ихт ХХК	Экспорт	2015.01.01- 2015.12.31	109,781.8	109,583.7	198.0	19.8	2,571.9	2,552.1
Нийт буцаан олголт								7,695.6
Хангад- Эксплорэйшн ХХК	Экспорт	2010.01.01- 2015.10.30	82,894.7	41,525.2	41,369.5	4,136.9	11,363.1	7,226.2
Нийт буцаан олголт								7,226.2

Эх сурвалж: ТЕГ, НӨАТ-ын баталгаажуулалтын актад хийсэн дүн шинжилгээ



Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Тухайн үеийн албан тушаал	Овог нэр
1	НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хугацааг шалгалтын хамрах хугацаа, АТСТ-ийн үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан үндэслэлтэй тогтоох шаардлагатай байна	Зөвлөмж өгөх	Бодлогын асуудал-Сангийн сайд, Татварын ерөнхий газрын дарга Гааль, татварын ерөнхий газрын дарга	Б.Болор Б.Чойжилсүрэн Б.Ариунсан С.Пүрэв
2	Хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй, цөөн хэдхэн компаниудад НӨАТ-ын буцаалтыг тогтмол, их хэмжээгээр олгосон нь татварын тэгш, шударга байх зарчмыг алдагдуулж байна	Зөвлөмж өгөх	Бодлогын асуудал-Сангийн сайд, Татварын ерөнхий газрын дарга Гааль, татварын ерөнхий газрын дарга	Б.Болор Б.Чойжилсүрэн Б.Ариунсан С.Пүрэв
3	Том татвар төлөгчийн НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг дахин хянаж, баталгаажуулахгүй байна	Зөвлөмж өгөх	Хууль, эрх зүйн орчинтой холбоотой бодлогын асуудал	
4	Татварын тайлангийн систем албан татвар суутган төлөгчид НӨАТ ногдох орлогоос хасагдах зардлыг нэмэгдүүлэх боломжийг олгож байна	Зөвлөмж өгөх	Хууль, эрх зүйн орчинтой холбоотой бодлогын асуудал	
5	НӨАТ ногдох орлогоос төлбөр хийгдээгүй НӨАТ-тэй худалдан авалтыг хасч, НӨАТ-ын буцаалтыг хууль зөрчин олгосон байна	Зөвлөмж өгөх	Татварын улсын байцаагч	Б.Халиунаа, Ц.Бундхорол, Р.Долгорсүрэн, П.Отгонсүрэн
6	НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулахдаа хамаарал бүхий этгээдийн хооронд хийгдсэн гүйлгээг иж бүрэн шалгадаггүйгээс тэдгээр нь татвараас зайлсхийх зорилгоор зах зээлийн үнээс доогуур эсвэл өндөр үнээр хоорондоо гэрээ байгуулан НӨАТ-тай худалдан авалтыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн байж болзошгүй байна.	Зөвлөмж өгөх	Татварын ерөнхий газрын дарга Гааль, татварын ерөнхий газрын дарга, Улсын төсвийн орлого хяналтын газрын дарга, Татварын хяналт шалгалтын хэлтсийн дарга, Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газар	Б.Ариунсан С.Пүрэв, М.Энхбаяр, н.Сүрэнхорлоо, Б.Батбилэг Д.Энхбаяр Ж.Ганбат
7	НӨАТ-ын илүү төлөлтийг албан татвараас өөр өр төлбөрт шилжүүлэх, АТСТ-ийн харилцагчдын албан татварын өрийг суутган тооцох зэргээр хууль зөрчсөн байна	Зөвлөмж өгөх	Татварын ерөнхий газрын дарга Гааль, татварын ерөнхий газрын дарга Улсын төсвийн орлого хяналтын газрын дарга, Татварын хяналт шалгалтын хэлтсийн дарга, Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газар	Б.Ариунсан С.Пүрэв, М.Энхбаяр, н.Сүрэнхорлоо, Б.Батбилэг Д.Энхбаяр Ж.Ганбат
8	Ил тодын тайлан гаргасан АТСТ нарт хууль зөрчин НӨАТ-ын буцаалтыг олгосон байж болзошгүй байна	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлэх		



9	Худалдан борлуулах зорилгогүй үндсэн хөрөнгөд төлсөн НӨАТ-ыг НӨАТ ногдох орлогоос хасч, их хэмжээний буцаалтыг олгосон байна	Зөвлөмж өгөх	Татварын ерөнхий газрын дарга Гааль, татварын ерөнхий газрын дарга Улсын төсвийн орлого хяналтын газрын дарга, Татварын хяналт шалгалтын хэлтсийн дарга, Дэд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар	Б.Ариунсан С.Пүрэв, М.Энхбаяр, н.Сүрэнхорлоо, Б.Батбилэг Д.Энхбаяр Б.Ганцэцэг Ж.Ганбат
10	АТСТ биш иргэн, ААН-үүдийн дийлэнх нь НӨАТУС-д бүртгүүлээгүй, зарим АТСТ нар НӨАТУС-ийг бүрэн ашиглахгүй байгаагаас албан татвар төлөгч нар НӨАТ-ын урамшуулалд бүрэн хамрагдахгүй, татвар төлөгчдийн борлуулалт бүрэн бүртгэгдэхгүй байх эрсдэл үүсч байна	Зөвлөмж өгөх	Хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудал Гааль татварын ерөнхий газрын дарга Татвар төлөгчтэй харилцах газрын дарга	С.Пүрэв, Д.Баяраа н.Орхон Д.Цогзолмаа
11	НӨАТУС-ээс хэвлэгдсэн нийт баримтын 50.2 хувь баталгаажуулаагүй байгаа нь иргэдэд хүргэх сургалт сурталчилгааны үр дүн хангалтгүй байгааг харуулж байна			
12	2017 оны эхний хагас жилийн байдлаар НӨАТ-ын буцаан олголтыг авбал зохих нийт татвар төлөгчийн 122.9 мянга буюу 19.8 хувь нь 461.3 сая төгрөгийн буцаан олголтыг аваагүй байгаа нь тэдний хувийн мэдээлэл бүрэн бус, дансны мэдээлэл зөрүүтэй, хамтран эзэмшигчтэй данс бүртгүүлснээс шалтгаалсан байна. Монгол банк дахь буцаан олголтын тусгай данс 461.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тус үлдэгдлийг тодорхой давтамжтайгаар улсын төсөвт төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүйтэй холбоотой байна.			
13	НӨАТ-ын урамшуулал олголтын эрсдэлийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтоож, хянах аргачлалыг сайжруулах шаардлагатай байна.	Зөвлөмж өгөх	Татварын Ерөнхий газрын дарга Эрсдэлийн удирдлагын хэлтэс	С.Пүрэв, Д.Хүрэлчулуун
14	Дотоод хяналтыг холбогдох журам, зохицуулалтад нийцүүлэн хэрэгжүүлээгүй байна	Зөвлөмж өгөх	Сангийн сайд, ГТСМТТөвийн захирал, ТЕГ, Дотоод аудитын газрын дарга	Б.Болор Б.Чойжилсүрэн, Р.Отгонтулга, Б.Орхонтамир н.Орхон Д.Сайханчулуун
15	Төрийн өмчийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, зохиогчийн эрхийг баталгаажуулаагүйгээс өмч, хөрөнгөд эрсдэл гарч болзошгүй байна	Зөвлөмж өгөх	Татварын ерөнхий газрын дарга, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Нягтлан бодогч Дотоод аудитын газрын дарга	С.Пүрэв С.Төгсжаргал н.Бат-Очир
16	Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтот Сангийн яамнаас тавих хяналт хангалтгүй байна	Зөвлөмж өгөх	Маргаан таслах зөвлөлийн дарга, Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газар	Ж.Ганбат
17	ПОС машин нийлүүлэгч компаниудын нэгдсэн бүртгэлгүй, тэдгээрт тавих хяналт байхгүй байна	Зөвлөмж өгөх	Хууль, эрх зүйн орчинтой холбоотой асуудал	
18	Маргаан таслах зөвлөл гомдлыг шийдвэрлэхдээ хууль, журамд заасан хугацааг баримтлахгүй байна	Зөвлөмж өгөх	Маргаан таслах зөвлөлийн дарга, Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газар	Ж.Ганбат



Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн

19	Үндэслэлгүй акт тогтоосон татварын улсын байцаагчдад Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй уялдуулан хариуцлага тооцох ажил огт хийгдээгүй байна	Зөвлөмж өгөх	Маргаан таслах зөвлөлийн дарга, Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газар	Ж.Ганбат
20	Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаа бие даасан, хараат бус, бусдын нөлөөнд үл автах зарчим алдагдах эрсдэлтэй байна	Зөвлөмж өгөх	Хууль, эрх зүйн орчинтой холбоотой, бодлогын асуудал	



Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал



2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Сангийн яам, Татварын ерөнхий газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Татварын ерөнхий газар /Д.Занданбат/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор /М.Давааням/-д даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Tushaal\2018\0501GAG1.Docx

070598

[illegible]